



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ



УСНББОУС 1

Санхүүгийн тайлангийн толилуулга



ЗОРИЛГО: Байгууллагын санхүүгийн тайланг өмнөх үед бэлтгэсэн болон бусад байгууллагын бэлтгэсэн санхүүгийн тайлантай зэрэгцүүлэх боломжтойгоор бэлтгэх аргыг тодорхойлох.

Хамрах хүрээ

- Нягтлан бодох бүртгэлийн Аккруэл сууриар гаргаж, толилуулах нийтлэг зориулалттай бүх санхүүгийн тайлан бэлтгэхэд
- Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан бэлтгэдэг улсын үйлдвэрийн газраас бусад **бүх байгууллагад** адил тэгш хэрэглэнэ.

Хураангуйлсан завсрын санхүүгийн мэдээлэлд энэ стандартыг хэрэглэхгүй

Тодорхойлолт

- **Аккруэл суурь** – Ажил гүйлгээ ба бусад үйл явцыг гарсан үед нь (мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг хүлээн авсан эсвэл төлсөн эсэхээс хамаарахгүй) хүлээн зөвшөөрдөг нягтлан бодох бүртгэлийн суурь юм.
- **Нийтлэг зориулалттай санхүүгийн тайлан** – тусгай мэдээлэл шаардах хэрэглэгчээс бусад хэрэглэгчийн хэрэгцээг хангахад чиглэсэн тайлан болно.
- **Улсын үйлдвэрийн газар** гэж дараах бүх шинжийг агуулсан байгууллага юм
 - а) Байгууллага нь өөрийн нэрийн өмнөөс гэрээ хийх эрхтэй
 - б) Бизнес эрхлэн явуулах санхүүгийн болон үйл ажиллагааны эрх олгогдсон байх
 - в) Бизнесийн хэвийн нөхцөлд бараа болон үйлчилгээг ашигтайгаар эсвэл өртгөө бүрэн нөхөгдөх байдлаар өөр байгууллагад борлуулдаг байх
 - д) Тасралтгүй байх зарчмыг хангахын тулд Засгийн газраас байнгын санхүүжилт авах эрмэлзэлгүй байх
 - е) Улсын секторын байгууллагын хяналтанд байх



Улсын секторын нийтлэг нийтлэг зориулалттай санхүүгийн тайлангийн зорилго

- Шийдвэр гаргагчийг чухал ач холбогдолтой мэдээллээр хангахын зэрэгцээ **байгууллагын өөрийн мэдэлд олгосон нөөцийн талаар хүлээсэн хариуцлагаа тайлагнах**
 - ✓ Санхүүгийн нөөцийн эх үүсвэр, хуваарилалт, ашиглалтын талаар мэдээллээр хангах
 - ✓ Байгууллага үйл ажиллагаагаа хэрхэн санхүүжүүлсэн болон мөнгөний хэрэгцээг хэрхэн хангасан талаар мэдээллээр хангах
 - ✓ Үйл ажиллагаагаа санхүүжүүлэх, өр төлбөр болон амлалтаа барагдуулах байгууллагын чадварыг үнэлэхэд чухал ач холбогдолтой мэдээллээр хангах
 - ✓ Байгууллагын санхүүгийн байдал болон түүний өөрчлөлтийн талаар мэдээллээр хангах
 - ✓ Үйлчилгээний өртөг, үр ашиг болон амжилт бүтээлээр нь байгууллагын үр дүнг үнэлэхэд чухал ач холбогдолтой нэгтгэсэн мэдээллээр хангах

Санхүүгийн тайлангийн чанарын шинжүүд

- Ойлгомжтой байх
- Хамааралтай байх
 - Цаг хугацаандаа байх
 - Материаллаг байх
- Итгэл үнэмшилтэй байх
 - Үнэн зөв илэрхийлэл
 - Мөн чанарыг хэлбэрээс илүүд үзэх
 - Төв гол байх
 - Хянамгай байх
 - Иж бүрэн бай
- Зэрэгцүүлэгдэх байдал





Хөрөнгийг хэмжих суурь

Түүхэн
өртөг

Өнөөгийн үнэ цэнэ

Зэх зээлийн
үнэ цэнэ


Орлуулалтын
өртөг

Борлуулалтын
цэвэр үнэ

Ашиглалтын
үнэ цэнэ



Өр төлбөрийг хэмжих суурь





Санхүүгийн тайлан ба Төсөв

Улсын секторын байгууллагын нийтлэг зориулалттай санхүүгийн тайлан нь хуулиар батлагдсан нөөцийг батлагдсан төсвийн дагуу олж бүрдүүлсэн ба зарцуулсан эсэх талаар мэдээллээр хангаж болно.

- a) **Батлагдсан төсвөө нийтэд тайлагнадаг** байгууллагууд нь УСНББОУС 24 *Санхүүгийн тайлан дахь төсвийн мэдээллийн толилуулга* стандартын шаардлагыг мөрдөнө.
- b) Бусад байгууллагын хувьд, санхүүгийн тайлан ба төсөв нь нягтлан бодох бүртгэлийн ижил сууриар бэлтгэгдсэн үед тайлангийн хугацааны төсвийн дүнтэй харьцуулсан зэрэгцүүлэлтийг санхүүгийн тайланд багтаахыг энэ стандартаар дэмждэг.
 - ✓ Төсөв гүйцэтгэлийн дүнг тусгай баганааар харуулсан санхүүгийн тайлангийн баганаан хэлбэрийг ашиглах
 - ✓ Иж бүрэн байдлыг хангахын тулд батлагдсан төсвийн зориулалтаас хэлбэлзсэн байдлыг харуулж толилуулах
 - ✓ Батлагдсан төсөв зориулалтаас хэтэрсэн эсвэл батлагдсан төсөвгүй юмуу бусад эрх мэдлийн хэлбэрээр зардал гарсан бол тодруулах
 - ✓ Байгууллагын үр дүнгийн үзүүлэлт (үйлчилгээний үр дүн, хөтөлбөрийн тойм), заавар журмын хэрэгжилтын талаарх мэдээлэл нь байгууллагад хуваарилах нөөцийн талаар шийдвэр гаргахад нөлөөлдөг бол тодруулахыг дэмжинэ



УСНББОУС 2

Мөнгөн гүйлгээний тайлан

Багш: А.Одгэрэл

БУ-ын Магистр, МНБ, Аудитор
СЭЗИС-ийн ахлах багш



УСНББОУС 2: Мөнгөн гүйлгээний тайлан

= Санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг

	A	B	C	D	E
1			[Company Name]		
2			Cash Flow Statement		
3					
4			For the Year Ending	12/31/2008	
5			Cash at Beginning of Year	15,700	
6					
7			Operations		
8			Cash receipts from customers	693,200	
9			Cash paid for		
10			Inventory purchases	(264,000)	
11			General operating and administrative expenses	(112,000)	
12			Wage expenses	(123,000)	
13			Interest	(13,500)	
14			Income taxes	(32,800)	
15			Net Cash Flow from Operations	147,900	
16					
17			Investing Activities		
18			Cash receipts from		
19			Sale of property and equipment	33,600	
20			Collection of principal on loans		
21			Sale of investment securities		
22			Cash paid for		
23			Purchase of property and equipment	(75,000)	
24			Making loans to other entities		
25			Purchase of investment securities		
26			Net Cash Flow from Investing Activities	(41,400)	
27					
28			Financing Activities		
29			Cash receipts from		
30			Issuance of stock		
31			Borrowing		
32			Cash paid for		
33			Repurchase of stock (treasury stock)		
34			Repayment of loans	(34,000)	
35			Dividends	(53,000)	
36			Net Cash Flow from Financing Activities	(87,000)	
37					
38			Net Increase in Cash	19,500	
39					
40			Cash at End of Year	35,200	
41			© 2008 Vertex42 LLC	Templates by Vertex42.com	



Энэ стандартын зорилго нь МГТ-ын тусламжтайгаар байгууллагын мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн түүхэн өөрчлөлтийн талаарх мэдээллээр хангах явдал.

МГТ нь мөнгөн орлогын эрс үүсвэр, зарцуулсан зүйлс, тухайн өдрөөр үлдэгдлийг тодорхойлж харуулдаг.

Байгууллага нь МГТ бэлтгэхдээ энэхүү стандартыг дагаж мөрдөнө.



УСНББОУС 2: Мөнгөн гүйлгээний тайлан

Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс

Мөнгө

Мөнгөтэй түүнтэй адилтгах зүйлс

Бэлэн
мөнгө



Харилцах



Богино хугацаат хөрөнгө



3 сараа бага
хугацаатай

Өмчийн хөрөнгө
оруулалт

Эдгээрийн орлого, зардлагын хөдөлгөөн = Мөнгөн гүйлгээ



УСНББОУС 2: Мөнгөн гүйлгээний тайлан

Мөнгөн гүйлгээ

Үндсэн үйл ажиллагаа

- ✓ Бараа, үйлчилгээний орлого
- ✓ Хүү, эрхийн шимтгэлээс бий болсон орлого
- ✓ Ажилтан/Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн төлбөр
- ✓ Даатгалын төлбөр
- ✓ Зарга, маргааныг барагдуулалттай холбоотой төлбөр
- ✓ Төлсөн татвар
- ✓ Төлсөн хүү

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа

- ✓ Үндсэн хөрөнгө/Биет бус хөрөнгө
- ✓ Өмчийн болон өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт
- ✓ Бусдад олгосон урьдчилгаа/зээл
- ✓ Фьючерс, форвард, опцион, свап хэлцэл

Санхүүгийн үйл ажиллагаа

- ✓ Өөрийн хувьцаа, өмчийн хэрэглүүр
- ✓ Зээл, өрийн бичиг, бонд
- ✓ Санхүүгийн түрээс

МӨНГӨНИЙ ОРОХ УРСГАЛ

МӨНГӨНИЙ ГАДАГШЛАХ УРСГАЛ



УСНББОУС 2: Мөнгөн гүйлгээний тайлан

Үндсэн үйл ажиллагааны мөнгө гүйлгээний тайлагнал

Шууд арга

- ✓ Гол хандлага
- ✓ Нийт мөнгөн орлого, зарлагыг гол ангиудаар нь толилуулдаг.

Шууд бус арга

- ✓ Үйл ажиллагааны цэвэр ашгийг мөнгөн гүйлгээ руу тохируулдаг.

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Бараа борлуулалтаас хүлээн авсан орлого	xxx
Нийлүүлэгчид төлсөн төлбөр	xxx
Ажилтанд төлсөн төлбөр	xxx
Төлсөн татвар	xxx
Төлсөн хүү	xxx
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	xxx

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

Үйл ажиллагааны цэвэр ашиг	xxx
Тохируулга:	xxx
Мөнгөн бус зүйлийн тохируулга	xxx
Ажлын капиталын өөрчлөлт	xxx
Төлсөн татвар	xxx
Төлсөн хүү	xxx
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	xxx



УСНББОУС 2: Мөнгөн гүйлгээний тайлан

Үндсэн үйл ажиллагааны
мөнгө гүйлгээний тайлагнал

Шууд арга

Шууд бус арга

Жишээ нь:


Дансны авлага

Эхний үлдэгдэл	50
Хүлээн зөвшөөрсөн орлого	100
Цуглуулсан авлага	
Эцсийн үлдэгдэл	20

50	130
100	
20	

Илүү авлага цуглуулжээ

- Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг тооцоолохдоо авлагын илүүдэл дүнг цэвэр орлого дээр нэмдэг.
- Үр дүнд нь:





УСНББОУС 2: Мөнгөн гүйлгээний тайлан





УСНББОУС 2: Мөнгөн гүйлгээний тайлан

Хүү, ногдол ашиг:



- ✓ Зардлаар бүртгэсэн болон капиталжуулсан хүүг аль алиныг нь мөнгөн гүйлгээний тайланд тодруулна.
- ✓ Санхүүгийн байгууллагуудын хувьд хүүг ихэвчлэн үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилна.
- ✓ Төлсөн болон хүлээн авсан хүү, ногдол ашгийг үндсэн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, санхүүжилтын гэдэг холбогдох шинж байдлаар нь нэг тайлант үе бүр тууштай ангилна.

Гадаад валютаар гарсан
мөнгөн гүйлгээ :



- ✓ Тайлагналын өдрөөрх хаалтын ханшаар хөрвүүлнэ.
- ✓ Ханшийн тэгшитгэлийн зөрүүнээс үүсэх олз/гарзыг мөнгөн гүйлгээ гэж үзэхгүй.
- ✓ Үндсэн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн мөнгөн гүйлгээний аль нэгэнд ангилахгүй.
- ✓ Ханшийн зөрүүнээс үүсэх олз/гарзыг мөнгөн гүйлгээний тайлангийн хөл хэсэгт толилуулна.



УСНББОУС 2: Мөнгөн гүйлгээний тайлан

Тодруулгын
шаардлага



- ✓ Мөнгөн хөрөнгийн томоохон дүнг, удирдлагын тайлбарын хийсэн хамт тодруулга
- ✓ Ирээдүйн үйл ажиллагаанд болон капиталын хариуцлагыг биелүүлэхэд ашиглах боломжтой ашиглаагүй зээлийн эх үүсвэрийн дүн, мөн эх үүсвэрийн ашиглалтад тавигдах аливаа хязгаарлалтууд
- ✓ Хязгаарлагдсан мөнгөн хөрөнгийн дүн болон шинж чанарыг тодруулж, тайлбарлана.



УСНББОУС 3

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, тооцооллын өөрчлөлт ба алдаа

Б.Баатарцогт

Мандах их сургуулийн багш



Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Тодорхойлолт

НББ-н бодлого гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахдаа байгууллагын мөрддөг үндсэн зарчим, суурь, дүрэм, журам, тогтсон практик юм.

А. НББ-н бодлогын сонголт, хэрэглээ:

1. Стандартад заасан бол стандартын дагуу
2. Хэрэв стандартгүй бол дараах эх сурвалжийг үндэслэн удирдлагын шийдэл гаргана
 1. Бусад стандарт дахь төстэй асуудлын шийдлийг ашиглана.
 2. Бусад стандарт болон үзэл баримтлалын хүлээн зөвшөөрөх шалгуур, тодорхойлолт
 3. Бусад үндэсний НББНХЗЗ (Зөрчилгүй гэж үзсэн тохиолдолд)

Б. НББ-ийг тууштай хэрэглэх шаардлагатай

В. Зөвхөн дараах нөхцөлд НББ-н бодлогыг өөрчилнө:

1. Шинэ стандарт эсхүл тайлбараар шаардсан бол
2. Илүү хамааралтай үнэн зөв мэдээллээр хангах



НББ-ийн бодлогын өөрчлөлтийг хэрэгжүүлэх

- **Буцаах горимыг хэрэглэх** Буцаан мөрдөх горим гэдэг нь нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг анхнаас нь хэрэглэж байсан мэтээр ажил гүйлгээ, бусад үйл явдал, болон нөхцөл байдлыг бүртгэх явдал юм
- Өмнөх үеийн болон өөрчлөлт орж буй хамгийн эхний үеийн мэдээллийг зэрэгцүүлэн тайлагнана.

Дараахаас бусад тохиолдолд мөрдөнө:

- Практик боломжгүй
- Шинэ стандарт эсхүл тайлбарт шилжилтийн тусгай нөхцөл заасан

Шаардлагатай тодруулга

- Өөрчлөлт оруулсан стандарт / тайлбарын гарчиг.
- Бодлогын өөрчлөлтийн тухай мэдээлэл.
- Шилжилтийн заалтуудын тайлбар.
- Одоогийн болон өмнөх үеүүдийн хувьд, боломжтой бол, нөлөөлж буй мөр бүрийн өөрчлөлтийг нийтэд мэдээлнэ.
- Хамгийн эрт тохирсон эхэн үеийн тохируулгын хэмжээг харуулна.

Өөрчлөлт эсхүл сайн дурын өөрчлөлт хийх шаардлагатай эсэхээс хамаарч дэлгэрэнгүй тодруулга хийнэ.



Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг санхүүгийн тайланг бэлтгэхэд ашиглагддаг гурван үндсэн үйл явцад холбож ангилж болно.

(1) хүлээн зөвшөөрөлт,

Жишээ Шууд хамааралтай зээлийн зардлыг зардлаар хүлээн зөвшөөрөх бус харин капиталжуулах

(2) дараа үеийн хэмжилт,

Жишээ Үндсэн хөрөнгийн нийт ангийн хувьд өртгийн загвараас дахин үнэлгээний загварт шилжих өөрчлөлт

(3) толилуулга-тай холбон ангилж болно.

Жишээ Үндсэн хөрөнгийн ашиглалтын өөрчлөлт (энэ бол нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт биш юм. Учир нь нөхцөл байдлын өөрчлөлтөөс бий болсон толилуулгын өөрчлөлт юм)



Дасгал ажил 1

НББ –н бодлогын өөрчлөлтөнд буцаан мөрдөх горим хэрэглэх

А байгууллага 2018 оны дундуур баригдаж байгаа усан цахилгаан станцыг авахтай шууд холбогдох зээлийн зардлыг бүртгэх нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчилсөн. Өмнөх тайлант үеүдэд байгууллага ийм зардлыг капиталжуулсан. Одоо байгууллага ийм зардлуудыг капиталжуулахын оронд зардалд бүртгэхээр шийдсэн. **Ингэх нь санхүүгийн зардлыг бүртгэх илүү ойлгомжтой аргачлал болох бөгөөд салбарын дотоодын практик туршлагатай нийцэн байгууллагын санхүүгийн тайлангийн харьцуулагдах боломжийг нэмэгдүүлэх үр дүнтэй учраас байгууллагын удирдлагын мэргэжлийн шийдэл нь энэ шинэ бодлогыг илүүд үзсэн.**

*А байгууллага 2017 онд гарсан **7,800,000₮**, 2017 оноос **өмнө гарсан 15,600,000₮-н** зээлийн зардлыг капиталжуулсан. Байгууллага цахилгаан станцыг авахтай холбоотой өмнөх жилүүдэд гарсан зээлийн бүх зардлыг капиталжуулсан. 2018 онд хүүний өмнөх ашиг /үр дүн/90,000,000₮, хүүний зардал 9,000,000₮ (зөвхөн 2018 онд хамаарах) байсан. Цахилгаан станц нь ашиглалтанд ороогүй байгаа учраас байгууллага үүнтэй холбоотой ямар нэг элэгдэл хүлээн зөвшөөрөөгүй.*



2017 оны хураангуйлсан санхүүгийн үр дүнгийн тайлан

Хүүний өмнөх ашиг	54,000,000₮
Хүүний зардал	-
Тайлант үеийн үр дүн /ашиг/	54,000,000₮

:



Хуримтлагдсан ашгийн 2017 оны эхний үлдэгдэл 60,000,000₮ ба эцсийн үлдэгдэл **114,000,000₮** байсан. А байгууллага энэ хугацаанд 30,000,000₮-н капиталтай байсан ба хуримтлагдсан ашгаас гадна цэвэр хөрөнгө/өмчийн өөр бүрэлдэхүүн байхгүй. Хураангуйлсан санхүүгийн үр дүнгийн тайлан

	2018 он	2017 он (дахин тайлагнасан)
Хүүний өмнөх ашиг	90,000,000₮	54,000,000₮
Хүүний зардал	(9,000,000₮)	(7,800,000₮)
Тайлант үеийн үр дүн /ашиг/	81,000,000₮	46,200,000₮



Хураангуйлсан цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	ЗГОК	ДҮН	Хур. үр дүн	Нийт
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	30,000,000₮		60,000,000₮	90,000,000₮
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(15,600,000₮)	(15,600,000₮)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	30,000,000₮		44,400,000₮	74,400,000₮
Тайлант үеийн үр дүн /цэвэр ашиг, алдагдал/			46,200,000₮	46,200,000₮
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	30,000,000₮		90,600,000₮	120,600,000₮
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	30,000,000₮		90,600,000₮	120,600,000₮
Тайлант үеийн үр дүн /цэвэр ашиг, алдагдал/			81,000,000₮	81,000,000₮
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	30,000,000₮		171,600,000₮	201,600,000₮



2018 онд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой журналын бичилт:

Дт Хуримтлагдсан үр дүн /эхний үлдэгдэл рүү/ 23,400,000₮

Кт Дуусаагүй барилга 23,400,000₮



НББ-ийн тооцооллын өөрчлөлт

Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт нь алдааны залруулгаас бус **харин шинэ мэдээлэл эсвэл хөгжил дэвшлээс** бий болдог.

- Найдваргүй авлага
- Бараа материалын хоцрогдол, хуучрал
- Баталгааны үүрэг хариуцлага,
- Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг дахин тооцох гэх мэт

Тооцооллын өөрчлөлтийг бүртгэх горим

Өөрчлөлтийн нөлөөг ашиг, алдагдалд дараах байдлаар хүлээн зөвшөөрнө.

- Хэрэв тухайн хугацаанд нөлөөлөх бол өөрчлөлтийн хугацаа; эсвэл
- Өөрчлөлт хийх хугацаа ба ирээдүйн хугацаа (боломжтой бол).

НББ-ийн алдаа

- Математик үйлдлийн алдаа
- НББ-ийн бодлогыг мөрдөхөд гаргасан алдаа
- Бодит байдалд хайнга хандалт буюу түүнийг буруу тайлбарлалт
- Залилан

Алдааг засварлах горим

НББ-ийн дараагийн тайлант үед илрүүлсэн бол дахин **буцаан тайлагналт** буюу бүх алдааг өнгөрсөн хугацаанд засч залруулах.

- Алдаа гарсан үеүдийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг дахин тооцоолох

Тодруулга: Хийсэн засварын дүн ба мөн чанарыг тодруулах буюу эсвэл дахин тайлагнах нь практик боломжгүй бол түүний талаарх тайлбар.



Дасгал ажил 2: Тооцооллын өөрчлөлт

2013.01.01-нд 10 жилийн ашиглалтын хугацаатай, 11,000,000₮-ийн үлдэх өртөгтэй, 51,000,000₮-ийн үнэтэй тоног төхөөрөмж худалдан авсан. Элэгдлийг шулуун шугамын аргаар тооцдог. 2019.01.01-нд буюу 6 жилийн дараа тус хөрөнгийн үлдэх өртөг 7,000,000₮ ба цаашид ашиглах хугацаа 8 жил гэдгийг тогтоосон бол **2019 оны элэгдлийг зардлыг тооцоольё.**



Бодолт:

Элэгдүүлэх хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үлдэх өртөг өөрчлөгдөж байгаа учраас тооцооллын өөрчлөлт гэж үзэж, өөрчлөлт гарснаас хойш гүйцээн мөрдөх горимыг ашиглана.

2019.01.01-рх тоног төхөөрөмжийн дансны үнийг тооцно.

Дансны үнэ = Анхны өртөг – Хуримтлагдсан элэгдэл – Хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарз

Жишээний хувьд Дансны үнэ = 51,000,000₮ - 24,000,000₮ = 27,000,000₮

2019 оны элэгдлийн зардлыг тооцоходоо тооцооллын өөрчлөлт гарсан өдрөөрх дансны үнээс шинэчилж тооцсон үлдэх өртгийг хасч, гарсан дүнг цаашдын ашиглалтын хугацаанд хуваарилна.

2019 оны элэгдлийн зардал = 2,500,000₮



Дасгал ажил 3 : Алдааг өмнөх үерүү дахин тайлагнах

Байгууллага 2019 онд татварын орлого буруу байсныг илрүүлсэн. Уг 13,000,000₮-н татварын орлогыг 2018 онд хүлээн зөвшөөрөх байсан ч 2019 онд орлогод хүлээн зөвшөөрсөн байсан. Байгууллагын 2019 онд 120,000,000₮-н татварын орлого (үүнд 13,000,000₮ багтсан), 173,000,000₮ зардлыг бүртгэсэн.

2018 онд байгууллагын үр дүнгийн тайланд:

Татварын орлого	68,000,000₮
Хэрэглэгчийн хураамж	6,000,000₮
Үйл ажиллагааны бусад орлого	<u>60,000,000₮</u>
Нийт орлого	134,000,000₮
Зардал	(120,000,000₮)
Үр дүн	<u>14,000,000₮</u>



Байгууллагад өөр орлого, зардал байхгүй ба 2018 оны хуримтлагдсан үр дүндансны эхний үлдэгдэл 40,000,000₮, эцсийн үлдэгдэл 54,000,000₮ байсан. 10,000,000₮-н засгийн газрын оруулсан капитал, хуримтлагдсан үр дүнгээс гадна өмчид өөр бүрэлдэхүүн байхгүй.

- 2019 оны 12 сарын 31-рх Санхүүгийн үр дүнгийн тайлан

	2019	2018 (дахин тайлагнасан)
Татварын орлого	107,000,000₮	81,000,000₮
Хэрэглэгчийн хураамж	8,000,000₮	6,000,000₮
Үйл ажиллагааны бусад орлого	<u>80,000,000₮</u>	<u>60,000,000₮</u>
Нийт орлого	195,000,000₮	147,000,000₮
Зардал	(173,000,000₮)	(120,000,000₮)
Үр дүн	<u>22,000,000₮</u>	<u>27,000,000₮</u>



2019 оны 12 сарын 31-рх Өмчийн өөрчлөлтийн тайлан

	ЗГОК	Хур.үр дүн	Нийт
2018 оны 01 сарын 01-рх үлдэгдэл	10,000,000₮	40,000,000₮	50,000,000₮
Тайлант үеийн үр дүн (дахин тайлагнасан)		27,000,000₮	27,000,000₮
2018 оны 12 сарын 31-рх үлдэгдэл	10,000,000₮	67,000,000₮	77,000,000₮
Тайлант үеийн үр дүн		22,000,000₮	22,000,000₮
2019 оны 12 сарын 31-рх үлдэгдэл	10,000,000₮	89,000,000₮	99,000,000₮



Санхүүгийн тайлангийн тодруулгын хэсэгт

2018 оны санхүүгийн тайланд 13,000,000₮-н татварын орлогыг орхигдуулсан. Энэ алдааг залруулах зорилгоор 2018 оны санхүүгийн тайлангуудыг дахин тайлагнасан. Эдгээр санхүүгийн тайлангуудын дахин тайлагналын нөлөөг доорх байдлаар нэгтгэв. 2019 онд ямар нэг нөлөө байхгүй.

	2018 онд нөлөөлөл
Орлогын өсөлт	13,000,000₮
Хуримтлагдсан үр дүнгийн өсөлт	<u>13,000,000₮</u>
Авлагын өсөлт	13,000,000₮
Цэвэр хөрөнгө/өмчийн өсөлт	<u>13,000,000₮</u>



УСНББОУС 5

Зээлийн өртөг

Б.Баатарцогт
Мандах их сургуулийн багш



Агуулга

1. Стандартын зорилго, юунд ашиглах вэ?
2. Хүлээн зөвшөөрөлт
3. Тодруулга



1. Зорилго

Энэ Стандарт нь зээлийн өртгийн нягтлан бодох бүртгэлийн хандлагыг тодорхойлно. Энэ Стандарт нь **зээлийн өртгийг нэн даруй зардал болгохыг ерөнхийдөө шаарддаг**. Гэвч шалгуур хангах хөрөнгийн худалдан авалт, барьж байгуулалт буюу үйлдвэрлэлтэнд шууд хамаарах зээлийн өртгийг зөвшөөрөгдсөн сонголтог хандлага байдлаар **капиталжуулахыг** энэхүү Стандартаар зөвшөөрдөг.



Зээлийн өртөг гэж юу вэ?

- *Мөнгөн санг зээлдэн авахтай холбоотойгоор байгууллагын гаргах хүү болон бусад зардлууд*
 - Банкны овердрафт, богино болон урт хугацаат зээлийн хүү;
 - Зээлтэй холбоотой хөнгөлөлт, урамшууллын хорогдуулга;
 - Зээлийн гэрээтэй холбоотойгоор гарсан нэмэлт өртөг зардлын хорогдуулга;
 - Санхүүгийн түрээс болон үйлчилгээний концессын хэлцэлтэй холбоотой санхүүгийн хураамж; ба
 - Гадаад валютын зээлээс үүссэн бөгөөд хүүний зардлын тохируулга гэж үзэх тохиолдолд ханшийн зөрүү.



Шалгуур хангах хөрөнгө

Шалгуур хангах хөрөнгө гэдэг нь түүнийг зориулалтын дагуу ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгоход **нилээд их цаг хугацааг** зайлшгүй шаарддаг хөрөнгө юм

ҮҮНД:

- Бараа материал (УСНББОУС12-н дагуу) *-ашиглах буюу борлуулахад бэлэн тийм нөхцөл байдалд оруулахад мэдэгдэхүйц их цаг хугацаа шаардах*
- Үндсэн хөрөнгө- *оффисын барилга, эмнэлэг, түүнчлэн зам, гүүр, цахилгаан станц гэх мэт дэд бүтцийн хөрөнгө*
- Биет бус хөрөнгө
- Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө





2. Хүлээн зөвшөөрөлт

1. Зээлийн өртөг- Бенчмарк хандлага
2. Зээлийн өртөг-Зөвшөөрөгдсөн сонголтот хандлага



Зээлийн өртөг-Бенчмарк хандлага

Тухайн зээлийг хэрхэн ашигласнаас үл хамааран бенчмарк хандлагын дагуу зээлийн өртгийг тэдгээрийн гарсан тайлант үед зардал гэж хүлээн зөвшөөрнө.

Зээлийн өртгийн хувьд баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогыг санхүүгийн тайланд тодруулна.



Зээлийн өртөг-Зөвшөөрөгдсөн сонголтот хандлага

Шалгуур хангах хөрөнгийн худалдан авалт , барьж байгуулалт буюу үйлдвэрлэлд *шууд хамааруулж болох зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртгийн нэг хэсэг болгон капиталжуулна.* Капиталжуулах боломжтой зээлийн өртгийн дүнг тодорхойлно.

Шууд хамааруулж болох зээлийн өртөг нь хэрэв уг шалгуур хангах хөрөнгийн хувьд зарцуулалт хийгдээгүй бол гаргахгүйгээр зайлсхийж болох байсан зээлийн өртөг юм.



Анхаарах

- *Капиталжуулах дүн = Бодит зээлийн өртөг - зээллийн түр зуурын хөрөнгө оруулалтаас олсон орлого*
- *Тайлант үеийн туршид капиталжуулах зээлийн өртгийн дүн нь тухайн тайлант үед гарсан зээлийн өртгийн нийт дүнгээс **хэтрэх ёсгүй**.*
- *Капиталжуулалтын хувь хэмжээ = тайлант хугацааны тусгай бус зээлийн жигнэсэн дундаж өртөг*
- *Хяналт тавигч байгууллага нь хяналтанд байгаа байгууллагадаа мөнгөн санг ямар нэгэн хүүний зардалгүйгээр шилжүүлдэг бол нэгдмэл байгууллага нь зээлийн өртгийг капиталжуулж болно.*



Анхаарах

Капиталжуулалтыг эхлүүлэх

- Хөрөнгийн зардал гарсан:
- Зээлийн өртөг гарсан
- Ашиглах эсвэл борлуулах зорилготой хөрөнгийг бэлтгэхэд шаардлагатай үйл ажиллагаа эхэлсэн:



Капиталжуулалтыг хойшлуулах

Шалгуур хангах хөрөнгийн идэвхитэй хөгжүүлэлт тасалдсан тохиолдолд энэхүү сунгасан хугацааны туршид зээлийн өртгийн капиталжуулалтыг хойшлуулж, зардал болгоно.

Гэвч техникийн болон захиргаа удирдлагын томоохон ажлыг хийж байгаа бол тухайн тайлант үеийн туршид зээлийн өртгийн капиталжуулалтыг ихэвчлэн хойшлуулдаггүй.



Капиталжуулалтыг зогсоох

Шалгуур хангах хөрөнгийг түүний зориулалтын ашиглалт эсвэл борлуулалтанд бэлтгэхэд шаардлагатай бараг бүх үйл ажиллагаа дууссан үед зээлийн өртгийн капиталжуулалтыг зогсооно.

Захиргаа удирдлагын өдөр тутмын ажил үргэлжилсэн хэвээр байж болох боловч тухайн хөрөнгийг биетээр барьж байгуулах ажиллагаа дууссан тохиолдолд хөрөнгө нь түүний зориулалтын ашиглалт эсвэл борлуулалтанд ихэвчлэн бэлэн болсон гэж үзнэ.



Анхаарах

Шалгуур хангах хөрөнгийн барилгын ажил хэсэгчлэн дууссан бөгөөд бусад хэсгүүдийн барилгын ажил үргэлжлэн явагдаж байх үед уг дууссан хэсэг тус бүрийг ашиглах боломжтой тохиолдолд тэрхүү дууссан хэсгийг зориулалтын дагуу ашиглалт буюу борлуулалтанд бэлтгэхэд шаардлагатай бараг бүх ажиллагаа дууссан үеэр түүний зээлийн өртгийн капиталжуулалтыг зогсооно.



3. Тодруулга

Санхүүгийн тайланд дараах зүйлсийг тодруулна:

- Зээлийн өртгийн хувьд баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого;
- Тухайн тайлант үеийн туршид капиталжуулсан зээлийн өртг ийн дүн
- Капиталжуулалтын хувь хэмжээ

2001 оны 7-р сарын 1-с эхлэн дагаж мөрдсөн.



Дасгал ажил 1

А нь агуулахын барилга барьж байгаа. Тайлан жилийн эхний өдөр **300,000,000₮ зарцуулж**, тухайн жилийн турш уг зардлаар барилгын ажлыг үргэлжлүүлсэн. Уг ажилд зориулж

- 200,000,000₮-н тусгай зээлийг жилийн 5%-н хүүтэй авсан.

Бусад өр төлбөрүүд:

- Жилийн 8%-н 200,000,000₮ бондын өр

- Жилийн 12%-н 200,000,000₮ банкны зээлтэй бол
УСНББОУС5-н дагуу хүүний зардлыг хэрхэн бүртгэхэд
шийдэл гарга



Бодолт

Хүүгийн капиталжуулалтын
эхлэл шалгуур хангах уу

- Хөрөнгийн зардал гарсан
- Зээлийн өртөг гарсан
- Үйл ажиллагаа эхэлсэн

Шалгуур хангаж байна

- Хэрхэн бүртгэх вэ?

Зээлийн зардлын **гол хандлагаар бол** зээлийг яаж хэрэглэснээс үл хамааран түүнийг гарсан тайлангийн үед нь зардал гэж хүлээн зөвшөөрнө.

Хүүний зардалд 50,000,000₮ бүртгэнэ.

Зөвшөөрөгдсөн сонголтот хандлагын дагуу бол бодит хүүний зардлаас илүүгүй хүүг капиталжуулж болно.

Капиталжуулах хүү = 200,000,000₮ x 5% + (300,000,000₮ - 200,000,000₮) x 10% = 20,000,000₮



УСНББОУС 9

Арилжааны ажил гүйлгээний орлого


Х.Нямбаяр

Мандах их сургуулийн багш



Орлого: Өмч эзэмшигчдээс оруулсан хувь оролцооноос бусдаар цэвэр хөрөнгө /өмчийг өсгөх нөлөөтэй хөрөнгийн орлогын гүйлгээ буюу сайжралт, эсвэл өр төлбөрийн бууралт хэлбэрээр тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн өгөөжийн өсөлт юм.

Арилжааны ажил
гүйлгээний
орлого



Арилжааны бус
ажил гүйлгээний
орлого

Хүлээн зөвшөөрөлт: Ирээдүйн эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхийг байгууллага хүртэх магадлалтай бөгөөд уг өгөөжийг хэмжих боломжтой бол орлогыг хүлээн зөвшөөрнө.



Арилжааны ба арилжааны бус ажил гүйлгээ

Арилжааны ажил гүйлгээ

- Бараа, үйлчилгээний худалдан авалт буюу борлуулалт;
- Зээлийн хүү;
- Эрхийн шимтгэл буюу лицензийн төлбөр;
- Хөрөнгө оруулалтын ногдол ашиг.

Арилжааны бус ажил гүйлгээ

- Татвар ногдуулалт;
- засгийн газрын татаас;
- Сургалтын төлбөрийн тэтгэлэг;
- Хандив;
- Торгууль.

Тодорхойлолт: УСНББОУС 9: Арилжааны ажил гүйлгээ

Тухайн байгууллага хөрөнгө буюу үйлчилгээг хүлээн авах, эсвэл өр төлбөрийг барагдуулах ба үүний хариуд ойролцоогоор тэнцүү үнэ цэнэ бүхий зүйлсийг нөгөө талдаа өгдөг ажил гүйлгээ



Орлогын хэмжилт

Орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар тооцсон төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ.

Борлуулалтын хөнгөлөлт, буцаалт зэрэг нь орлогыг бууруулна. Бараа борлуулалтын төлбөр нь хэд хэдэн үеийн туршид хийгдэх бөгөөд хүүгийн төлбөр агуулж байвал өнөөгийн үнэ цэнээр бүртгэх хэрэгтэй.

Бараа солилцох ажил гүйлгээ



Хүлээн авсан барааны бодит үнэ цэнийг талууд хоорондоо шилжүүлсэн мөнгөөр залруулсан дүн байна.

Өгсөн барааны бодит үнэ цэнийг талууд хоорондоо шилжүүлсэн мөнгөөр залруулсан дүн



Хүлээн зөвшөөрөлт:

Барааны борлуулалт

- a) Мэдэгдэхүйц эрсдэл/ өгөөжийг шилжүүлэх
- b) Удирдлагын оролцоог зогсоох
- c) Орлогыг найдвартай хэмжих боломжтой байх
- d) Ирээдүйн эдийн засгийн өгөөж орох магадлалтай байх
- e) Ажил гүйлгээний өртгийг найдвартай хэмжих боломжтой байх.

Үйлчилгээний орлого

- a) Орлогыг найдвартай хэмжих боломжтой байх
- b) Ирээдүйн эдийн засгийн өгөөж орох магадлалтай байх
- c) Ажил гүйлгээний өртгийг ул үндэслэлтэйгээр хэмжих боломжтой байх.
- d) Үе шатуудын бүрдлийг ул үндэслэлтэйгээр хэмжих боломжтой байх



Бараа борлуулалт- Өмчлөлийн эрсдэл өгөөжийг шилжүүлдэг.

Анхаарах асуудал

Буцаах эрх

Буцаалтын түвшин (Буцаасан бараа/Борлуулалт) өндөртэй зарим байгууллагын туршлагаар буцаах эрхийн хугацаа нилээд хэмжээгээр дуусах хүртэл орлогыг хойшлуулах шаардлагатай гэж үздэг.

Суурилуулалт ба угсралт


Борлуулсан барааг худалдан авагч тал хүлээн авсан бөгөөд борлуулагч суурилуулалт болон техникийн хяналтыг гүйцэтгэхээр гэрээнд заасан бол гэрээний үүрэг биелтэл өмчлөлийн эрсдэл болон өгөөж нь худалдан авагч талд шилжихгүй. Өөрөөр хэлбэл орлогыг хүлээн зөвшөөрөхгүй.

Авлага цуглуулалт

Барааг зээлээр борлуулсан бөгөөд төлбөр хийх магадлал бага үед орлогыг хүлээн зөвшөөрөхгүй. Худалдан авагч нь эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр төлбөр хийдэг тохиолдолд энэ нөхцөл байдал үүсч болно.



Үйлчилгээний орлогыг гүйцэтгэлийн хувийн жингийн аргаар хүлээн зөвшөөрөх.



*Үе шатны гүйцэтгэлийг сайн тооцооллын дагуу шулуун шугамын аргыг ашиглаж болно.



Үйл явцын өрнөлийг үнэлэх (Гүйцэтгэлийг тодорхойлох)

- **Гүйцэтгэсэн ажлын судалгаа**

Гүйцэтгэсэн ажлаа гүйцэтгэвэл зохих ажилтай харьцуулдаг.

- **Хугацааг үндэслэх арга**

Гүйцэтгэвэл зохих графикт хугацаа ба тайлангийн хугацааг харьцуулдаг.

- **Гүйцэтгэлийн хувийн жингийн арга**

Гүйцэтгэлийн зардал ба тооцоолсон нийт өртгийн харьцаагаар тодорхойлогдоно.



Жишээ нь: Сургалтын орлого

Нийт орлого 100₮

Нийт зардал 50₮

Нийт 120 цаг сургалт, 12 сар үргэлжилнэ.

Тайлант сард 10 цагийн сургалт зохион байгуулсан. 5₮-ийн зардал гарсан



Гүйцэтгэсэн ажлын судалгаа

Сургалтын орлого

Нийт орлого 100₮

Нийт зардал 50₮

Нийт 120 цаг сургалт, 12 сар
үргэлжилнэ.

Тайлант сард 10 цагийн сургалт
зохион байгуулсан. 5₮-ийн зардал
гарсан

$$\text{Гүйцэтгэл} = 10/120 = 8.3\%$$

$$\text{Орлого} = 50 \times 8.3\% = 4.15₮$$



Хугацааг үндэслэх арга

Сургалтын орлого

Нийт орлого 100₮

Нийт зардал 50₮

Нийт 120 цаг сургалт, 12 сар
үргэлжилнэ.

Тайлант сард 10 цагийн сургалт
зохион байгуулсан. 5₮-ийн зардал
гарсан

$$\text{Гүйцэтгэл} = 1/12 = 8.3\%$$

$$\text{Орлого} = 50 \times 8.3\% = 4.15₮$$



Гүйцэтгэлийн хувийн жингийн арга

Сургалтын орлого

Нийт орлого 100₮

Нийт зардал 50₮

Нийт 120 цаг сургалт, 12 сар
үргэлжилнэ.

Тайлант сард 10 цагийн сургалт
зохион байгуулсан. 5₮-ийн зардал
гарсан

$$\text{Гүйцэтгэл} = 5/50 = 10\%$$

$$\text{Орлого} = 50 \times 10\% = 5₮$$



Хүү, ногдол ашиг, эрхийн төлбөр

Хүү

Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах зүйлээ бусдад ашиглуулсны хөлс, эсвэл бусдаас авах авлагаа хойшлуулсны төлөө авах төлбөр

Эрхийн төлбөр

Удаан эдэлгээтэй, тухайлбал патент, худалдааны тэмдэг, зохиогчийн эрх, цахим тооцоолуурын программ хангамж зэрэг хөрөнгөө ашиглуулсны орлого

Ногдол ашиг

Тодорхой ангиллын капиталын эзэмшилд оролцож байгаа хувь хэмжээгээр нь хувьцаат хөрөнгө эзэмшигчдэд хуваарилсан ашгийн хуваарилалт



Тодруулга

Байгууллага нь дараах
зүйлсийг тодруулах
шаардлагатай:

Орлогыг хүлээн
зөвшөөрөхөд
баримтласан НББ-ийн
бодлого,
үүнд үйлчилгээ
үзүүлэхтэй холбогдсон
ажил гүйлгээний
бүрдэлтийн үе шатыг
тодорхойлоход
ашигласан аргууд;

Бараа ба үйлчилгээг
солилцох замаар
үүссэн орлогын гол
нэр төрөл тус
бүрээр тусгагдсан
орлогын дүн

Гол, нэр төрөл тус бүрээр орлогын дүн, түүн дотор
доорхи үйл ажиллагаанаас орсон орлогыг:

1. Бараа борлуулалт;
2. Үйлчилгээ үзүүлэх;
3. Хүү;
4. Лицензийн төлбөр; ба
5. Ногдол ашиг.



Үйлчилгээний төрөл	Хүлээн зөвшөөрөлт
Байраар хангах	?
Сургуулийн тээвэр	?
Төлбөртэй зам, зогсоол	?
Шүүх ажиллагаа	?
Шинжлэх ухаан, технологийн судалгаа	?
Суурилуулалтын хөлс	?



Үйлчилгээний төрөл	Хүлээн зөвшөөрөлт
Байраар хангах	<u>Гэрээний нөхцлийн дагуу</u>
Сургуулийн тээвэр	<u>Тээврийн үйлчилгээг үзүүлсэн үед</u>
Төлбөртэй зам, зогсоол	<u>Замын ашиглалтыг үндэслэн</u>
Шүүх ажиллагаа	<u>Үйл явцын иж бүрдэлтийн үе шатыг лавлагаа болгон эсвэл тайлант үеүдэд шүүх хурал явагдсан байдлыг үндэслэн</u>
Шинжлэх ухаан, технологийн судалгаа	<u>Тухайн төслүүдийн иж бүрдэлтийн үе шаттай уялдуулан</u>
Суурилуулалтын хөлс	<u>Суурилуулалтын иж бүрдэлтийн үе шатыг баримтлан</u>



Үйлчилгээний төрөл	Хүлээн зөвшөөрөлт
Бүтээгдэхүүний үнэд багтсан үйлчилгээний төлбөр	?
Нийтийн үйлчилгээний хураамж	?
Сургалтын төлбөр	?



Үйлчилгээний төрөл	Хүлээн зөвшөөрөлт
Бүтээгдэхүүний үнэд багтсан үйлчилгээний төлбөр	<u>Үйлчилгээг гүйцэтгэх тайлант үед</u>
Нийтийн үйлчилгээний хураамж	<u>Урлагийн тоглолт, цайллага ба бусад тусгай үйл явдлын орлогыг уг үйл явдал болсон үед хүлээн зөвшөөрнө.</u> <u>Үйл явдал тус бүрт ямар үйлчилгээг үзүүлснийг харгалзах сууриар үйл явдал бүрт хураамжийг хуваарилана.</u>
Сургалтын төлбөр	<u>Сургалтын хугацаанд хүлээн зөвшөөрнө. Өөрөөр хэлбэл сургалтын үйлчилгээг үзүүлснээр орлогоор бүртгэнэ.</u>



Танилцуулга:

- **Үндсэн хөрөнгийн ангилал,**
- **Бүрэлдэхүүн хэсгээр бүртгэх ба хөрөнгийн бүлэглэл**

Багш: Э.Жавзандулам
СЭЗИС-ийн багш



Үндсэн хөрөнгийн хяналтын асуудал

- “Хөрөнгө гэдэг нь **өнгөрсөн үйл явдлын** үр дүнд аж ахуйн нэгж **хяналтандаа** оруулсан бөгөөд түүнээс уг аж ахуйн нэгжид **ирээдүйн эдийн засгийн үр өгөөж эсвэл үзүүлсэн үйлчилгээнээс** орохоор хүлээгдэж буй нөөц юм”.
- Хөрөнгийн хяналт- байгууллага нь өөрийн зорилтондоо хүрэх явцад хөрөнгийг ашиглах эсвэл ямар нэгэн байдлаар хөрөнгийн үр өгөөжийг хүртэх, тэр үр өгөөжийг хүртэх боломжийг бусдаас ямар нэгэн байдлаар хязгаарлаж чадахуйц нөхцлийг хэлнэ.
- **Хууль ёсны эзэмшил нь хөрөнгийн бүртгэлд шаардлагагүй ба хяналт нь шийдвэрлэх хүчин зүйл!**


Гол тодорхойлолт

Бараа материал: Хэвийн үйл ажиллагааны явцад зарцуулагдахаар эсвэл худалдан борлуулахаар эзэмшиж байгаа, эсвэл үйлдвэрлэлийн процесст эсвэл үйлчилгээ үзүүлэхэд ашиглан зарцуулагдах материал буюу хангамжийн зүйлсийг хэлнэ.

Үндсэн хөрөнгө: Бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэд ашиглах, бусдад түрээслэх эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа; ба нэгээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж буй биет зүйлсийг хэлнэ.



Үндсэн хөрөнгө болон Бараа материал – Шийдвэрийн мод





Жишээ./Хөрөнгийн ангилал/

- а) Гал унтраах машин нь ус хадгалах савтай. Байгууллага нь 6,000,000 төгрөгийн үнэтэй гал унтраах машиндаа зориулж ус хадгалах шинэ савыг нөөцөнд худалдан авсан. Гэнэтийн үйлчилгээний үед гал унтраах хоёр машины ус хадгалах сав цоорсон байсан ба илүү нөөц савыг бэлэн байлгах шаардлагатай гэж үзсэн. Одоо гэмтэлтэй байгаа гал унтраах машины усны савыг орлуулан солих зорилгоор дээрх худалдан авалтыг хийсэн. Гал унтраах машинд орлуулан сольсон усны савыг 10,000,000 төгрөгөөр худалдан авсан. Худалдан авалтын өдөр галын машиныг ашиглах хугацаа 15 жил. Хуучин усны сав нь 5 жилийн ашиглалтын хугацаатай байсны улмаас шинэ усны савыг худалдан авсан.

Үндсэн хөрөнгө

- б) а) өгөгдлийн хувьд усны нөөц савыг 3,000,000 төгрөгөөр худалдан авсан.

Бараа материал

- с) 7,500,000 төгрөгийн галын хор зэрэг аюулгүйн хэрэгсэл худалдан авсан.

Гүйцэтгэх нь:

Үндсэн хөрөнгө

Дээрх ажил гүйлгээний хувьд, *капиталжуулалтын босго* нь 5,000,000 төгрөг бол нягтлан бодох бүртгэлийн зөв арга хандлагыг санал болгоно уу.



Бүрэлдэхүүн хэсгээр бүртгэх ба хөрөнгийн бүлэглэл

- “Үндсэн хөрөнгийн тухайн зүйлийн нийт өртөгтэй харьцуулахад мэдэгдэхүйц өртөг бүхий хэсэг бүрийг тусад нь элэгдүүлнэ.”
- Тухайн үндсэн хөрөнгийн зүйлийн тодорхой хэсгийн хувьд орлуулан нэмэгдэж буй зүйлсийн өртгийг капиталжуулах ба орлуулсан зүйлийг данснаас хасна.
- Үндсэн хөрөнгийн бүртгэлийг гол хэсгүүдийн задаргаагаар бүртгэж, тус бүрт нь элэгдлийг тооцож, орлуулах үед данснаас хасах ёстой.

Жишээ нь: Далавчийг 20 жил
элэгдүүлнэ

Жишээ нь:
Суудлыг 8 жилээр
элэгдүүлнэ



Жишээ нь: Хөдөлгүүрийг 6 жилээр элэгдүүлнэ



Бүрэлдэхүүний арга (үргэлжлэл)

Тодорхойло.



- Хөрөнгө нь дан ганцаар ашиглагддаггүй ба нэгдмэл процессд хэрэглэгддэг.
 - Жишээ нь: усны савтай гал унтраах машин; усны сав нь тусдаа хөрөнгө биш. Нисэх онгоц нь тусдаа ашиглагдаж болох ялгаатай бүрэлдхүүн хэсгүүдтэй тул тусад нь бүртгэнэ.



Хөрөнгийг бүлэглэх (үргэлжлэл)

Дан ганц хөрөнгө – Нэг худалдан авалтын захиалга / Гэрээт тохиролцоо

- Дан ганц хөрөнгийг нэг худалдан авалтын захиалга / Гэрээт тохиролцоогоор олж авсан бол-Үндсэн хөрөнгө болон Бараа материалын шийдвэрийн модыг ашиглан хөрөнгийн тохиромжтой ангилалаар бүртгэнэ.

Олон тооны хөрөнгө – Нэг худалдан авалтын захиалга / Гэрээт тохиролцоо

- Төрөл бүрийн хөрөнгийг нэг худалдан авалтын захиалга / Гэрээт тохиролцоогоор олж авсан бол, тухайн хөрөнгүүд нь тус тусдаа тодорхойлогдож чадах эсэх болон хөрөнгө тус бүрийн өртгийг тодорхойлох боломжтой эсэхийг үнэлнэ.
- Тусдаа тодорхойлогдож чадахуйц болон дангаараа ашиглагдах шинж чанартай хөрөнгийг үндсэн хөрөнгө болон Бараа материалын шийдвэрийн модыг ашиглан хөрөнгийн тохиромжтой ангилалаар бүртгэнэ.



Хөрөнгийг бүлэглэх (үргэлжлэл)

Олон тооны адил хөрөнгө – Нэг худалдан авалтын захиалга / Гэрээт тохиролцоо

- **Адилхан бүлэг хөрөнгийг нэг худалдан авалтын захиалга / Гэрээт тохиролцоогоор** авсан бол, хөрөнгүүдийг дангаар эсвэл бүлгээр нь ашиглах боломжтой эсэхийг тодорхойлох нь гол асуудал юм.
- Хэрвээ хөрөнгө нь бараа материал гэж ангилагдаж, дангаар нь ашиглах боломжтой бол, практикт тус хөрөнгийг ашигласан үедээ зардлаар бүртгэнэ. Үндсэн хөрөнгө гэж ангилсан хөрөнгийн хувьд, тухайн хөрөнгийг НББ-д бүртгэхэд ашиглах материаллагын босгыг тогтоож өгнө.



УСНББОУС 12

Бараа материал

Багш: Э.Жавзандулам

СЭЗИС-ийн багш



Бараа материалын тодорхойлолт

Бараа материал гэдэг нь:

- Бизнесийн хэвийн нөхцөлд худалдан борлуулахаар эзэмшиж байгаа
- Ингэж борлуулахын тулд үйлдвэрлэлийн процесст байгаа
- Үйлдвэрлэлийн процесст болон үйлчилгээ үзүүлэхэд зарцуулагдах материал эсвэл хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа хөрөнгийг хэлнэ.





Бараа материалын өртөг

Бараа материалыг одоогийн байршил болон төлөв байдалд оруулахтай холбоотой гарсан бүх зардал

Өртөгт орно:

- Худалдан авсан үнэ
- + Импортын татвар болон бусад буцаан үл олгогдох татварууд
- + худалдан авалтад хамаарах тээврийн зардал
- - Хасах нь худалдааны хөнгөлөлт эсхүл хямдруулалт

Үйлдвэрлэлийн зардалд хамаарах:

- Шууд хөдөлмөр
- шууд/хувьсах нэмэгдэл зардал
- Тогтмол нэмэгдэл зардлын хуваарилалт
- (үйл ажиллагааны хэвийн түвшинд суурилсан)



Бараа материалыг одоогийн байршил болон төлөв байдалд оруулахтай холбоотой бусад зардлууд

Тээврийн зардал:

- Үндсэн зорилгоор нь ашиглахаар одоогийн байршил болон төлөв байдалд авчрах зардалд орно.
- Дараа үед гарсан тээврийн зардал хамаарахгүй.
- Хэмжилтийн аргыг тодруулна.



Үнэлгээний залруулга – Арилжааны ажил гүйлгээ

Арилжааны ажил гүйлгээ гэдэг нь нэг байгууллага хөрөнгө буюу үйлчилгээг хүлээн авах (эсвэл өгөх), эсвэл өр төлбөрийг барагдуулах ба үүний хариуд ойролцоогоор тэнцүү үнэ цэнэ бүхий зүйлсийг нөгөө талд шууд өгдөг (эсвэл хүлээн авдаг) ажил гүйлгээг хэлнэ.

Анхдагч хэмжилт- худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнэ.

Дараа үеийн хэмжилт – өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар.

Тодруулга: “Данснаас хасах” нь засгийн газарт ялгаатай- НББ дэх үнийн цэнийн залруулга төдий бус биетээр нь данснаас хасах зөвшөөрөл

Үнэлгээний залруулга – Арилжааны бус ажил гүйлгээ

Арилжааны бус ажил гүйлгээ гэдэг нь: байгууллага хариуд нь ойролцоогоор тэнцүү үнэ цэнэ бүхий зүйлийг шууд өгөхгүйгээр (эсвэл авахгүйгээр) нөгөө талаас үнэ цэнэтэй зүйлийг хүлээн авдаг (эсвэл өгдөг).

Худалдан авалтын өдрөөрх бодит үнэ цэнээр хэмжинэ.

Өртөг болон орлуулалтын өртгийн аль багаар хэмжигдэнэ.



Арилжааны ажил гүйлгээний үнэ цэнийн бууралт

Цэвэр боломжит үнэ цэнэ гэдэг нь бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгох ба борлуулахад шаардлагатай тооцоолсон өртөг, зардлыг хассан дүн юм.


Үүнийг дараах байдлаар тооцоолно:		\$
Борлуулахаар тооцсон үнэ		X
Хасах нь: иж бүрдэл болгох тооцоолсон өртөг	(X)	
Хасах нь: борлуулах болон хуваарилахад шаардлагатай тооцоолсон өртөг	(X)	
		X



Арилжааны бус ажил гүйлгээний үнэ цэнийн бууралт

**Арилжааны бус ажил гүйлгээгээр худалдан авсан бараа материал
(мөнгө төлж аваагүй гэсэн үг)**

Дараа үеийн хэмжилт нь дараахийн аль бага нь байна:





Жишээ. /Бараа материалын дараа үеийн хэмжилт/

Байгууллага нь 100,000 төгрөгийн өртөгтэй бараа материалтай. Бараа материалын орлуулах өртөг нь 90,000 төгрөг. Тухайн барааг борлуулах эсвэл дотооддоо ашиглахын тулд нэмэлт 25,000 төгрөгийн зардал гарна.

Хэрэв барааг борлуулахаар бол борлуулалтын зардал нь 10,000 төгрөг.

Гүйцэтгэх нь:

Доорхи 3 хувилбар бүрт, УСНББОУС-ын дагуу бараа материалын үнэ цэнийг тодорхойлно уу:

- i. Бараа материалыг үйлчилгээ үзүүлэхэд л ашиглах ба дахин борлуулах үнэгүй.
- ii. Хүлээгдэж байгаа борлуулах үнэ нь 150,000 төгрөг.
- iii. Хүлээгдэж байгаа борлуулах үнэ нь 120,000 төгрөг.

**Жишээ. /Бараа материалын дараа үеийн хэмжилт/**

- i. Өртөг = 100,000 Орлуулах өртөг = 90,000  90,000 төгрөг
Дт Бараа материалын үнийн бууралтын гарз 10,000
Кт Бараа материал 10,000
- ii. ЦБҮЦ = 150,000 – 25,000 – 10,000 = 115,000 Өртөг = 100,000
 100,000 төгрөг
- iii. ЦБҮЦ = 120,000 – 25,000 – 10,000 = 85,000 Өртөг = 100,000
 85,000 төгрөг
Дт Бараа материалын үнийн бууралтын гарз 15,000
Кт Бараа материал 15,000



Жишээ. /Бараа материалын дараа үеийн хэмжилт/

Байгууллагад жилийн эцсээр 4 төрлийн бараа материал үлдэгдэлтэй байв. Эдгээрийн өртөг болон цэвэр боломжит үнэ цэнэ нь (ЦБҮЦ) дараах байдалтай байсан:

БМ-ын зүйлс	Өртөг	ЦБҮЦ	Орлуулалтын өртөг
1	27,000	32,000	25,000
2	14,000	8,000	10,000
3	43,000	N/A	40,000
4	29,000	N/A	31,000

Гүйцэтгэх нь:

Дээрх дурдсан, бараа материалд хийсэн залруулгын журналын бичилтийг хийнэ үү.

**Жишээ. /Бараа материалын дараа үеийн хэмжилт/**

Бараа материал ын зүйлс	Өртөг	ЦБҮЦ	Орлуулалт ын өртөг	Аль бага нь
1	27,000	32,000	25,000	
2	14,000	8,000	10,000	
3	43,000	-	40,000	
4	29,000	-	31,000	
Дүн	113,000			

Дт Бараа материалын үнийн бууралтын гарз 9,000

Кт Бараа материал 9,000



Өртөг тооцох онолын аргууд

а) ЭАЭЗ:

Эхэлж худалдан авсан/үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг эхэлж борлуулна гэж төсөөлдөг.

Тайлант үеийн эцэст үлдэж байгаа бараа материал нь хамгийн сүүлд худалдан авсан/үйлдвэрлэсэн зүйлс байх юм гэж төсөөлдөг.

б) Дундаж өртөг (ДӨ)

Дундаж өртгийг 2 янзаар тооцож болно.

Энгийн дундаж өртөг: Тайлант үед худалдан авсан/үйлдвэрлэсэн бүх зардлыг худалдан авсан нийт тоонд хуваадаг.

Жинэлсэн дундаж өртөг: тайлант үеийн эхэнд байсан ижил төрлийн бараа материал ба тухайн тайлант үеийн туршид худалдаж авсан буюу үйлдвэрлэсэн ижил төрлийн бараа материалын жинэлсэн дундаж өртгөөр тухайн бараа материал зүйл тус бүрийн өртгийг тодорхойлдог.



УСНББОУС 17

Үндсэн хөрөнгө

Багш: Э.Жавзандулам

СЭЗИС-ийн багш



Тодорхойлолт

Үндсэн хөрөнгө нь:

- Дараах зорилгоор эзэмшиж байгаа **биет зүйлсийг хэлнэ:**
 - Бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ашиглах
 - Бусдад түрээслэх, эсвэл
 - Удирдлагын зорилгоор болон
- **1 жилээс** дээш хугацаанд ашиглагдахаар хүлээгдэж байгаа

ҮХ-ийн тодорхойлолтыг хангах зүйлсүүд:

- Сэлбэг хэрэгсэл
- Үйлчилгээний төхөөрөмж
- Хангамжийн нөөц (Жишээ нь: аяга тавга)
- Аюулгүйн хэрэгсэл.





Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн үеийн хэмжилт

Удирдлагын төлөвлөсөн арга маягаар ажиллуулах боломжтой болгоход шаардлагатай тийм байршил болон нөхцөл байдалд уг хөрөнгийг авчрахад шууд хамааралтай аливаа өртөг зардал

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрнө.

Өртөгт орох элементүүд:

- **Худалдан авсан үнээс хасах нь** худалдааны хөнгөлөлт ба хямдруулалт
- Импортын татвар
- **Буцаан төлөгдөхгүй худалдааны татварууд**
- **Зээлийн өртөг**

Худалдан авалтын үнэ
(хөнгөлөлтийг хассан)

Шууд хамааралтай
зардал (удирдлага
төлөвлөсний дагуу ажиллах
боломжтой)

Устгах, чөлөөлөх
зардлын анхны
тооцоолол зардал
(хуулиар болон бусад үүргээр
бий болсон)

Зээлийн өртөг (барьж
байгуулах болон олж эзэмших
үеийн зээлийн сан)



Шууд хамааралтай өртөг зардлууд

- ✓ Шууд хамаарах ажилчны тэтгэмжийн зардал
- ✓ Хөрөнгийг ашиглахтай холбоотой гарсан аюулгүй байдал болон байгаль орчны зардал
- ✓ Газар талбайг бэлтгэх зардал
- ✓ Анхны хүргэлт ба ачиж, буулгах зардал
- ✓ Суурилуулалт ба угсралтын зардал
- ✓ Туршилтын зардал
- ✓ Мэргэжлийн үйлчилгээний зардал
- × шинэ үйлдвэр нээх зардал
- × шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулах зардал
- × шинэ байрлалд эсвэл шинэ хэрэглэгчидтэй бизнес хийхэд гарах зардал
- × Хөрөнгийг ашиглаж эхлэхээс өмнө гарсан зардал
- × Хөрөнгийг дахин хувиарлах зардал
- × Ашиглаж эхлэхээс өмнөх үйл ажиллагааны алдагдал





Жишээ. /Үндсэн хөрөнгө/

Зам, дэд бүтцийн яамны харьяанд дэд бүтцийн барилгын ажлыг хариуцдаг дотоод төслийн удирдлагын байгууллага байдаг. Жил бүр баригдаж байгаа төслийн тоо тогтмол бус. Жишээ нь, ойрын жилд нэг ч төсөл баригдаагүй байхад энэ жилд хэд хэдэн зам, гүүр баригдаж байгаа.

Энэ газар нь 20 ажилтантай бөгөөд боловсон хүчний задаргааг дор үзүүлэв:

- Газрын дарга (1 хүн) жилийн цалин 150,000,000 төгрөг
- Төслийн менежер (5 хүн) – 1 менежерийн жилийн цалин 75,000,000 төгрөг тус бүрдээ
- Нарийн бичиг болон туслах ажилтан (14)- дундаж цалин нь 40,000,000 төгрөг
- Төслийн менежерүүдэд зайлшгүй шаардлагатай шинэ хууль, тогтоомжийн талаарх дотоодын сургалт 15,000,000 төгрөг

Түүнчлэн, төслийн удирдлагын багийн түрээсийн болон оффисын тогтмол зардлын жилийн нийт дүн 100,000,000 төгрөг.

Гүйцэтгэх нь:

Дотоод төслийн удирдлагын зардлыг дэд бүтцийн төслүүдэд тайлант жилд капиталжуулах уу үгүй юу гэдгийг ярилц.



Жишээ. /Үндсэн хөрөнгө/

Зардлын задаргаа	Капиталжих эсэх	ДҮН
Газрын даргын цалии	тийм	150,000,000
Төслийн менежерийн цалин	тийм	375,000,000
Нарийн бичиг болон туслах ажилтаны цалин	тийм	960,000,000
Дотоод сургалт	тийм	15,000,000
Түрээсийн боон оффисын тогтмол зардал	тийм	100,000,000
		1,600,000,000



Татан буулгах зардал

- Анхны тооцоолол:
 - Хөрөнгийг задлан буулган зөөх ба
 - Хөрөнгө байршиж байсан талбайг дахин сэргээх
- Үүрэг нь дараах үед үүснэ:
 - Худалдан авах үед , эсвэл
 - Бараа материал үйлдвэрлэхээс өөр зорилгоор ашигласны үр дүнд.



Анхдагч хэмжилт

- Арилжааны/солилцооны бус ажил гүйлгээг бодит үнэ цэнээр хэмжинэ.
- Мөнгөн бус солилцоо биш байх, мөн өгсөн болон хүлээн авсан хөрөнгийн аль алиных нь бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжгүй байхаас бусад тохиолдолд солилцооны ажил гүйлгээг өртгөөр нь (ажил гүйлгээ нь бодит үнэ цэнээр хийгдсэн гэж таамагласан) хэмжинэ.
- Хүлээж авсан ба өгсөн хөрөнгийн аль алиных нь бодит үнэ цэнэ болон мөнгөн бус солилцоог найдвартай хэмжих боломжгүй бол солилцооны ажил гүйлгээг өртгөөр нь хэмжинэ.

Жишээ. /Үндсэн хөрөнгө/

Засгийн газар 20,000,000 төгрөгийн үнэтэй эмнэлгийн тэргийг
Улаан Загалмайгаас 5,000,000 төгрөгөөр худалдан авсан.

Гүйцэтгэх нь:

Эмнэлгийн тэргийг бүртгэх нягтлан бодох бүртгэлийн зөв арга хандлагыг тодорхойл.

• Дт	Үндсэн хөрөнгө	20,000,000
	Кт	Мөнгөн хөрөнгө
		5,000,000
	Кт	Солилцооны орлого
		15,000,000



Арилжааны зорилго агуулсан –Солилцооны ажил гүйлгээ

- а) Хүлээн авсан хөрөнгийн мөнгөн урсгалын хэв шинж (эрсдэл, цаг хугацаа, ба дүн) нь шилжүүлсэн хөрөнгийн мөнгөн урсгалын хэв шинжээс ялгаатай байх; эсвэл
- б) Солилцооны ажил гүйлгээ нь байгууллагын үйл ажиллагааны онцгой үнэ цэнэ бүхий хэсэгт зохих хэмжээгээр нөлөөлсөн бол; ба
- с) Солилцсон хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоход дээрх (а) ба (b)-д заасан нөхцөл мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн бол



Дараа үеийн зардал – Засвар болон үйлчилгээ

- Байнгын засвар болон үйлчилгээний зардлыг ихэвчлэн зардал гарсан үед нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.
- Дараа үеийн зарлага нь үнэ цэнийг нэмэгдүүлж байвал тухайн хөрөнгийн өртгийн хэсэг гэж хүлээн зөвшөөрнө.

Капиталжуулах удирдамж:

- Хөрөнгийн ашиглах жилийг нэмэгдүүлнэ
- Хөрөнгийн гарцын чанарыг нэмэгдүүлнэ
- Хөрөнгийн гарцын тоо хэмжээг нэмэгдүүлнэ
- Үйл ажиллагааны зардлыг бууруулна
- Томоохон үзлэг – хөрөнгө (бүрэлдэхүүн) болон үзлэг хоорондын тооцоолсон хугацааны туршид элэгдүүлнэ



Өөрөө барьж байгуулсан хөрөнгө

Үндсэн хөрөнгийг олж авах эсвэл барьж эзэмших үйл явцыг 4 шатанд ангилж болно:

1. Урьдчилсан шат

- Судалгааны үе
- Тодорхой хөрөнгө үгүй
- Бүх өртгийг зардлаар бүртгэнэ

2. Эзэмшихээс өмнөх шат

- Гэрээ зурагдахаас өмнө
- Хөрөнгө нь тодорхой
- Болзошгүй бол бүх шууд хамааралтай зардлуудыг капиталжуулна.
 - Хөрөнгийг ашигласнаар ирээдүйд эдийн засгийн үр өгөөж хүртэнэ гэдэг нь болзошгүй гэдгийг капиталжуулахаас өмнө тогтоох нь нэн чухал.

3. Олж авах эсвэл барих шат

- Барилгын үед зардлыг капиталжуулна

4. Үйлчилгээний шат

- Ихэнх өртгийг зардлаар бүртгэнэ
- Одоо ашиглаж буй бүрэлдэхүүнийг орлуулах, нэгээс дээш тайлант жилд нөлөөлөх томоохон засварын зардлыг капиталжуулна

**Жишээ. /Үндсэн хөрөнгийн өртөг/**

Шинэ байшингийн загвар, барилгын ажилтай холбоотой дараах зардлууд 20X1 онд гарсан:

	₮'000
Газар	900
Архитекторын төлбөр	100
Талбайн цэвэрлэгээ (хөндлөнгийн нураах/буулгах мэргэжлийн хүмүүс).	80
Барилга нурааснаас олох бусад орлого	(100)
Импортоор авсан тавилга	120
Тавилга импортоор худалдаж авахад зориулж төлсөн банкны баталгааны зардал	10
Барилга барихад ашиглагдсан бараа материалын өртөг	30
(Өртөг нь УСНББОУС 12-ийн дагуу тодорхойлогдсон ба ЦБҮЦ нь 24,000 төгрөг)	
Дотоодын барилгын ажилчдын цалингийн зардал	600
Барилгын талбайг агуулахын зориулалттай түрээсэлснээс орж ирсэн орлого (Барилгын ажлын эхэн шатанд)	<u>(35)</u>
	<u>1,705</u>

Гүйцэтгэх нь:

Дээрх зардлуудаас 20X1 онд Үндсэн хөрөнгөнд капиталжуулах зардлуудыг тодорхойлно уу.



	ДҮН ₮'000
Газар	
Архитекторын төлбөр	
Талбайн цэвэрлэгээ (хөндлөнгийн нураах/буулгах мэргэжлийн хүмүүс)	
Барилга нурааснаас олох бусад орлого	
Импортоор авсан тавилга	
Тавилга импортоор худалдаж авахад зориулж төлсөн банкны баталгааны зардал	
Барилга барихад ашиглагдсан бараа материалын өртөг 30 (Өртөг нь УСНББОУС 12-ийн дагуу тодорхойлогдсон ба ЦБҮЦ нь 24,000 төгрөг)	
Дотоодын барилгын ажилчдын цалингийн зардал	
Барилгын талбайг агуулахын зориулалттай түрээсэлснээс орж ирсэн орлого (Барилгын ажлын эхэн шатанд)	
Нийт дүн	



Түүхэн дурсгалт хөрөнгө

УСНББОУС 17 нь түүхэн дурсгалт хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн сонголтыг зөвшөөрдөг .

Түүхэн дурсгалт хөрөнгийн жишээнд түүхэн барилга, хөшөө дурсгал, археологийн талбарууд, дархан цаазтай газрууд, байгалийн нөөц ба урлагийн бүтээлүүд багтана.

Хэрвээ байгууллага нь түүхэн дурсгалт хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг бол, УСНББОУС 17-ийн дагуу тодруулгын шаардлагыг мөрдөх бөгөөд тухайн стандартын хэмжилтийн шаардлагыг мөрдөхийг шаарддаггүй.

Зарим хөрөнгүүдийг тэдгээрийн соёлын, байгаль орчны эсвэл түүхэн ач холбогдлын үүднээс түүхэн дурсгалт хөрөнгө гэж тодорхойлдог.



Нөөц тоног төхөөрөмж болон сэлбэгийн төрөл

1. Нөөц тоног төхөөрөмж :

- Аюулгүй ажиллагааны үүднээс эзэмшиж буй идэвхитэй ашиглагддаггүй хөрөнгө
- Нэн шаардлагатай ба ихэвчлэн өндөр үнэтэй
- Ашиглалтын хугацаа > 1 жил

НББ: Үндсэн хөрөнгийн бүртгэлийг ашиглана

2. Сэлбэг хэрэгсэл

- Бүрэлдэхүүн хэсгийг орлуулах зорилготой
- Солих хугацаа нь янз бүр

НББ: Үндсэн хөрөнгө (капиталжуулна) үү эсвэл Бараа материал (ашиглаж эхэлсэн үед зардалд хүлээн зөвшөөрнө) уу гэдгийг үнэлэх



Хүлээн зөвшөөрөлтийн дараах хэмжилт

Байгууллага нь доорх 2 сонголтоос сонгож болно :

- **Өртгийн загвар** (өртгөөс түүний аливаа хуримтлагдсан элэгдэл ба аливаа хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хасна)
- **Дахин үнэлгээний загвар** (дахин үнэлгээний өдрөөрх хөрөнгийн бодит үнэ цэнээс дараа үеийн аливаа хуримтлагдсан элэгдэл ба дараа үеийн хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн юм)
- Дахин үнэлгээний олзыг өмчийн дахин үнэлгээний нөөц данс руу кредитлэнэ.

- Хэрэв үндсэн хөрөнгийн зүйлийг дахин үнэлэх бол тухайн хөрөнгийн харъяалагдаж буй үндсэн хөрөнгийн нийт ангийг дахин үнэлнэ.

Дахин үнэлгээ-Давтамж

- Тайлагналын өдрөөрх дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү байхгүй гэдгийг хангалттай давтамжтайгаар баталгаажуулна.
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс хамаарна
- Ангилал доторх зүйлүүдийг богино хугацааны дотор дахин үнэлж болно.



ЭЛЭГДЭЛ



Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний
ашиглалтын хугацааны туршид
системчилсэн сууриар хуваарилна

Элэгдүүлэх дүн гэдэг
нь хөрөнгийн өртгөөс
эсвэл өртгийг орлох
бусад дүнгээс түүний
үлдэх өртгийг хассан
дүнг хэлнэ

Үлдэх өртөг: ашиглалтын
хугацааны (жил бүр дахин авч
үзнэ) эцэст хүлээгдэж буй
тэрхүү нөхцөл байдалд
хөрөнгийг данснаас хасахтай
холбоотой тооцоолсон дүн юм.

Ашиглалтын хугацаа:
тухайн хөрөнгөөс олж
авахаар хүлээгдэж буй
бүтээгдэхүүн буюу
түүнтэй ижил төсөөтэй
нэгжүүдийн тоо
хэмжээн дээр суурилдаг



ЭЛЭГДЭЛ



**Хөрөнгийн элэгдүүлэх
дүнг түүний ашиглалтын
хугацааны туршид
системчилсэн сууриар
хуваарилна**



**Ашиглахад бэлэн
болсон үеэс ба,
удирдлагын
төлөвлөсөн арга
маягаар
ажиллуулах
боломжтой болсон
үеэс эхлэн
элэгдүүлнэ**

**Ашиглагдаагүй
буюу идэвхитэй
ашиглалтаас
хасагдсан үед
элэгдлийг
зогсоохгүй**

**Үндсэн хөрөнгийн
тухайн зүйлийн
мэдэгдэхүйц өртөг
бүхий хэсэг
бүрийг тусад нь
элэгдүүлнэ**



УСНББОУС 13

Түрээс

Багш: А.Одгэрэл

БУ-ын Магистр, МНБ, Аудитор
СЭЗИС-ийн ахлах багш



УСНББОУС 13: Түрээс



2001 оны 12 сард анх гаргасан.

Зорилго



Санхүүгийн болон үйл ажиллагааны түрээстэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн хандлагыг түрээлэгч болон түрээслүүлэгчийн хувьд тодорхойлох

УСНББОУС 13-ийг дараахын хувьд мөрдөхгүй


- ✗ *Кино дүрс бичлэг, урлагийн тоглолт, гар бичмэл, патент, зохиогчийн эрх гэх мэт зүйлсийн лицензийн гэрээ*
- ✗ *Ашигт малтмал, газрын тос, байгалийн хий болон тэдгээртэй төсөөтэй үл нөхөн сэргээгдэх нөөцийн хайгуул, ашиглах зориулалттай түрээс*



УСНББОУС 13: Түрээсийн тодорхойлолт

Түрээс нь түрээслүүлэгч түрээслэгчид дараах зүйлийг шилжүүлж буй гэрээ хэлцэл юм:

1. Хөрөнгийг **ашиглах эрхийг**
2. Тохиролцсон тодорхой хугацаанд
3. **Төлбөр** эсвэл **цуврал төлбөрүүдийн** хариуд.





УСНББОУС 13: Түрээсийн тодорхойлолт

Гэрээ үүссэн өдөр:



ААН нь гэрээ нь
түрээсийн гэрээ эсвэл
бусад гэрээ мөн
эсэхийг тодорхойлно.

МӨН

Түрээсийн ангилалыг
тодорхойлно




Түрээслүүлэгч



ашиглалтыг
хянах эрхийг

тодорхойлсон
суурь хөрөнгө



Тодорхой хугацааны туршид

Төлбөрийн
хариуд



Түрээслэгч



УСНББОУС 13: Түрээсийн ангилал

Түрээсийн нөхцлүүд өөрчлөгдсөн тохиолдолд л түрээсийн ангилалыг дахин авч үзнэ.

Санхүүгийн түрээс

Хөрөнгийн эзэмшилтэй холбоотой **эрсдэл, өгөөжийг бараг бүхэлд** нь шилжүүлж буй түрээс.

Онцлог:

- Үл цуцлагдах
- Түрээсийн хугацаа нь ашиглалтын хугацааны дийлэнх
- Өмчлөх эрх шилжих боломжтой
- Хөрөнгийн ашиглалтад түрээслэгч тал хяналт тавих боломжтой

Үйл ажиллагааны түрээс

Хөрөнгийн эзэмшилтэй холбоотой **эрсдэл, өгөөжийг бараг бүхэлд** нь шилждэггүй буюу **санхүүгийн түрээсээс бусад түрээс**.

Онцлог:

- Цуцлагдах боломжтой
- Түрээсийн хугацаа нь ашиглалтын хугацааны багахан хэсэг
- Өмчлөх эрх шилжих боломжгүй
- Хөрөнгийн ашиглалтад түрээслүүлэгч тал хяналт тавих боломжтой



Түрээсийн ангилалыг илтгэх шалгуур



- Түрээсийн хугацааны эцэст **эзэмшил шилжих**
- **Худалдан авалтын** тохиролцоот **сонголт**
- **Түрээсийн хугацаа** нь хөрөнгийн ашиглалтын хугацааны **дийлэнх** байх
- **Түрээсийн хамгийн бага төлбөрүүдийн** өнөөгийн үнэ цэнийн анхны дүн нь хамгийн багадаа түрээслэж буй хөрөнгийн **бодит бүх үнэ цэнэтэй бараг тэнцүү байх**
- Томоохон тохируулга хийлгүйгээр зөвхөн түрээслэгч л ашиглаж чадахуйц тусгай хөрөнгө
- Түрээслэгч цуцалснаас хүлээх алдагдал
- Түрээслэгчид учрах үлдэгдэл үнэ цэнийн олз, гарз
- Түрээсийн хоёрдахь үе зах зээлийн түрээсийнхээс мэдэгдэхүйц бага байх

Аль нэгийг нь хангаж байвал **санхүүгийн түрээсээр** ангилна.

Авч үзэх бусад хүчин зүйлс



Түрээслэгчийн бүртгэл: Анх хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Санхүүгийн түрээс

Түрээсийн хөрөнгө болон өр
төлбөр дараахийн **аль бага
дүнгээр** хүлээн зөвшөөрнө.

Түрээсийн
төлбөрүүдийн
ӨҮЦ

Нуугдмал хүү

Өсөн нэмэгдэх зээлийн хүү

Түрээсийн
хөрөнгийн
бодит үнэ цэнэ

Үйл ажиллагааны түрээс

Түрээсийн зардлыг ШША-р
эсвэл өөр бусад системтэй
сууриар тайлант үеийн зардалд
хуваарилна.

Давхар бичилт:

Дт Түрээсийн зардал	xxx
Кт Мөнгөн хөрөнгө	xxx



Түрээслэгчийн бүртгэл: Анх хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Түрээсийн өр төлбөр

+

Анхдагч шууд зардлууд

/Түрээсийг олж авах гарсан өссөн нэмэгдэх зардал/

+

Урьдчилж төлсөн түрээсийн төлбөр

+

Буулгах/зөөх/дахин сэргээхэд гарах
тооцоолсон зардал

-

Хүлээн авсан түрээсийн урамшуулал

Түрээсийн хөрөнгийн өртөг:

Давхар бичилт:

Дт Түрээсийн хөрөнгө

Дт Мөнгөн хөрөнгө (Түрээсийн урамшуулал)

Кт Түрээсийн өр төлбөр – богино хугацаат

Кт Түрээсийн өр төлбөр – урт хугацаат

Кт Мөнгөн хөрөнгө (Түрээсийн төлбөр төлсөн)

Кт Мөнгөн хөрөнгө (анхдагч шууд зардлууд)



Түрээсийн өр төлбөр



Тогтмол төлбөр

+

Түрээсийн хувьсах төлбөр

+

Үлдэгдэл үнэ цэнийн баталгаа

+

Худалдан авах сонголтын хэрэгжих
үнэ

+

Гэрээ цуцалсны торгууль

- Мөн чанараараа тогтмол төлбөрт багтсан. Аливаа урамшууллын төлбөрийг хассан дүн.
- Эхлэлтийн өдөр индекс/ хувь хэмжээг ашиглан анх хэмжсэн, индекс/ хувь хэмжээнээс хамаардаг төлбөр
- Хэрэглээний үнийн индекстэй уялдаатай төлбөр, бэнчмарк хүүний түвшин
- Түрээслэгчийн төлөхөөр хүлээгдэж буй дүн

Хэрэв Түрээслэгч сонголтыг хэрэгжүүлэх нь **ул үндэслэлтэйгээр тодорхой байгаа**

Хэрэв **Түрээсийн хугацаа** нь Түрээслэгчийн цуцлах эрхийг тусгасан бол



Түрээслэгчийн бүртгэл: Санхүүгийн түрээс

Дараа үеийн хэмжилт

Түрээсийн хөрөнгө

Өртгийн загвар

Өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба
хуримтлагдсан ҮЦБ хассан дүнгээр
хэмжинэ.

Ашиглалтын
хугацаа

Аль богино

Түрээсийн
хугацаа

Түрээсийн өр төлбөр

Хорогдуулсан өртөгөөр хэмжинэ.

Түрээсийн хамгийн бага төлбөр

Санхүүгийн
зардал

Өр төлбөрийн
бууралт





Түрээсийн стандартын өөрчлөлтүүдийн талаарх ерөнхий мэдээлэл

- Үйл ажиллагааны түрээс ба санхүүгийн түрээс гэсэн түрээсийн ангилалыг байхгүй болгосон
- Нэг түрээслэгчийн нягтлан бодох бүртгэлийн загварыг танилцуулсан –
Түрээслэгч бараг бүх түрээсийн гэрээний хувьд ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх
- **12 сараас дээш хугацаатай бүх түрээсийн хувьд түрээсийн хөрөнгө ба өр төлбөр бүртгэх**
- Хэрэглэгч хөрөнгийн ашиглалтыг хянаж буй эсэх үндэслэн түрээс ба үйлчилгээний гэрээг ялгаж салгаж ангилах
- Богино хугацаатай, бага дүнтэй түрээсийг чөлөөлөх
- Түрээслүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн хувьд одоогийн удирдамж хэвээр үлдсэн



Түрээслэгчийн бүртгэл: Загвар

- Бүх түрээсийг баланст хүлээн зөвшөөрнө (зарим нь үл хамруулалтад багтана).
- Үр дүн нь одоогийн санхүүгийн түрээсийнхтэй адил.
- Зарим үл хамрагдах зүйлс бий: богино хугацаат түрээс (түрээсийн хугацаа 12 сараас бага) ба бага дүнтэй түрээс (бага дүнтэй хөрөнгө гэх мэт)

Ашиглах эрхийн загвар	
Баланс	Орлогын тайлан
Ашиглах эрхтэй хөрөнгө	Үйл ажиллагааны зардал:
Түрээсийн үүрэг	Хорогдол
	Хүүгийн зардал



УСНББОУС 14

Тайлангийн өдрийн дараах үйл явдал

Багш: Д.Бүнчинсүрэн

МУИС-ийн БС-ийн багш



Тодорхойлолт

- Тайлангийн өдөр ба санхүүгийн тайланг нийтэд гаргахыг зөвшөөрсөн өдрийн хооронд гарч тохиолдсон тааламжтай болон тааламжгүй үйл явдал

Хоёр гол асуулт тавигдана:

- Уг үйл явдал тайлангийн өдрийн дараа үүссэн боловч санхүүгийн тайланг гаргахыг баталгаажуулахаас өмнө тохиолдсон уу?
- Уг үйл явдал тайлангийн өдрөөр оршин байсан нөхцөл байдалтай холбоотой юу?



Балансын дараах ажил гүйлгээний хураангуй

Залруулах үйл явдал



Тайлангийн өдрөөр оршин байсан
нөхцөл байдал



Жишээ:

1. Шүүх дээр хэрэг шийдвэрлэгдэх
2. Гол харилцагчид дампуурах
3. Бараа материалын цэвэр боломжит
үнийн үнэлгээ
4. Залилан, алдааг илрүүлэх



Нягтлан бодох бүртгэлийн арга
хандлага:

Санхүүгийн тайлан дахь дүнг өөрчлөх

Үл залруулах үйл явдал



Тайлангийн өдрийн дараа үүсэн бий
болсон нөхцөл байдал



Жишээ:

1. Үер, гал зэргийн улмаас гол хөрөнгө
эвдэрч, гэмтэх
2. Чухал нөлөөтэй худалдан авалт
3. Хаалтын төлөвлөгөөг танилцуулах



Нягтлан бодох бүртгэлийн арга хандлага:
Зөвхөн тодруулна – Тайлбар тэмдэглэл

Тэмдэглэл: Үл залруулах үйл явдал нь тасралтгүй байдалд нөлөөлөхүйц байвал
залруулах үйл явдал болно.



Ногдол ашиг буюу адилтгах хуваарилалт

- Тайлангийн өдрийн дараа ногдол ашиг эсвэл адилтгах хуваарилалтыг олгохоор зарласан – өр төлбөр хүлээн зөвшөөрөхгүй
 - Зөвхөн тайлангийн өдрөөс өмнө олгохоор зарласан нөхцөлд л өр төлбөр үүснэ.
- Санхүүгийн тайланд тодруулгад толилуулна.



Тасралтгүй байх суурь

- Тасралтгүй байх төсөөллийн үнэлгээ хийнэ.
- Байгууллага дараах тохиолдолд санхүүгийн тайлангаа тасралтгүй байх сууриар бэлтгэхгүй:
 - Байгууллагын удирдлага буюу удирдах байгууллагын зүгээс татан буулгах буюу үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөсөн
 - Ингэхээс өөр бодит хувилбаргүй болсон гэдгээ тайлангийн өдрийн дараа тодорхойлсон
- Тухайлбал, тухайн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааг засгийн газрын өөр нэг байгууллагад шилжүүлсэн, эсвэл түүнийг борлуулсан буюу татан буулгасан эсэх



Дасгал ажил

Дараах ажил гүйлгээнүүд байгууллагын санхүүгийн жил дууссаны дараа боловч санхүүгийн тайланг нийтэд гаргахыг баталгаажуулахаас өмнө гарсан бөгөөд материаллаг нөлөөтэй. Эдгээрийн хувьд УСНББОУС 14-ийн дагуу санхүүгийн тайланд хэрхэн толилуулах вэ?

1. Тайлант жил дуусмагц солилцооны ажил гүйлгээгээр бараа материалыг анх худалдан авсан үнээс нь доогуур үнээр борлуулсан. Хэрэв энэ нь солилцооны бус ажил гүйлгээ байсан бол хариулт хэрхэн өөрчлөгдөх вэ эсвэл ямар нэмэлт мэдээлэл хэрэгтэй вэ?
2. Тайлант жилд хүчин төгөлдөр байсан орлого хуваах гэрээний дагуу өөр засгийн газартай хуваалцах орлогын дүнг тайлангийн өдрийн дараа тодорхойлсон.
3. Тайлант жил дууссаны дараахан газар хөдлөлтийн идэвхитэй бүст байрладаг барилга байгууламж газар хөдлөлтийн улмаас нурсан.



Дасгал ажил

Дараах ажил гүйлгээнүүд байгууллагын санхүүгийн жил дууссаны дараа боловч санхүүгийн тайланг нийтэд гаргахыг баталгаажуулахаас өмнө гарсан бөгөөд материаллаг нөлөөтэй. Эдгээрийн хувьд УСНББОУС 14-ийн дагуу санхүүгийн тайланд хэрхэн толилуулах вэ?

4. Ахмад настнуудын халаалтын зардалд зориулж мөнгөн татаас өгөх зорилгоор өвлийн хүйтэн саруудад тэдний цахилгааны төлбөрийн урьдчилж тохиролцсон хэсгийг төлөх замаар нийгмийн бүлэгт чиглэсэн үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүргийг нэгэн байгууллага хариуцан ажилладаг. Энэхүү хөтөлбөрт хамрагдсан иргэдэд тодорхой хугацааны туршид тус байгууллагын зүгээс нэмж халуун хоол, унд хүргэхээр тайлангийн өдрөөс өмнө шийдвэрлэсэн байсан.
5. Тайлангийн өдрийн дараа ажилтнуудад олгох урамшууллыг тооцоолохдоо тухайн жилийн гүйцэтгэлийн мэдээллийг өмнөх жилийн гүйцэтгэлтэй харьцуулдаг. Гүйцэтгэлийн үнэлгээг санхүүгийн жил дууссаны дараа хийсэн.



УСНББОУС 16

Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө

Багш: А.Одгэрэл

БУ-ын Магистр, МНБ, Аудитор
СЭЗИС-ийн ахлах багш



УСНББОУС 16: ХОЗҮХХ



2001 оны 12 сард анх гаргасан.

Зорилго



*ХОЗҮХХ-ийн нягтлан бодох бүртгэлийн хандлага,
холбогдох тодруулгын шаардлагыг тодорхойлох*

УСНББОУС 16-ийг дараах
зүйлсэд мөрдөхгүй

- ✗ *Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой биологийн хөрөнгө*
- ✗ *Газрын тос, байгалийн хий болон тэдгээртэй төсөөтэй үл нөхөн сэргээгдэх нөөц гэх ашигт малтмалын эрх ба ашигт малтмалын нөөц*



Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө



Эзэмшиж буй зорилго

- ✓ Түрээсийн орлого олох
- ✓ Капиталын үнийн өсөлтөөр ашиг олох

- ✗ Бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл болон удирдлагын зорилгоор ашиглах
- ✗ Хэвийн үйл ажиллагааны явцад худалдан борлуулах

Эзэн ашиглах
/Owner occupied/

Үл хөдлөх

- ✓ Газар
- ✓ Барилга
- ✓ Барилгын нэг хэсэг
- ✓ Газар ба барилгын аль аль нь





ХОЗҮХХ-н хүлээн зөвшөөрөлт :



Хүлээн зөвшөөрөх шалгуур

Ирээдүйд эдийн засгийн өгөөж
өгөх нэлээд магадлалтай байх

Өртөг буюу бодит үнэ цэнийг нь
найдвартай хэмжиж чадахуйц



ХОЗҮХХ-н хэмжилт:

Өртгөөр

- ✓ Худалдан авалтын үнэ
- ✓ Шууд хамаарах зардал

Бодит үнэ
цэнээр

- ✓ Арилжааны бус ажил
гүйлгээгээр олж авсан бол
өртөг нь БҮЦ тэй ижил
байна.



**ХОЗҮХХ-н хүлээн зөвшөөрөлтийн
дараа үеийн хэмжилт**

Бодит үнэ цэнийн загвар



Бодит үнэ цэнэ

Элэгдүүлэхгүй,
Олз эсвэл гарзыг орлогын
тайланд тусгана.

Бодит үнэ цэнийг найдвартай
хэмждэг байх

Өртгийн загвар



Өртөг – Хур Элэг – Хур ҮЦБ

УСНББОУС 17-д заасан өртгийн
аргыг ашиглан хэмжих ба үлдэх
үнэ цэнийг “Тэг” гэж үзнэ.

Бодит үнэ цэнийг найдвартай
хэмжих боломжтой болох хүртэл
ашиглана.



ХОЗҮХХ-ийн тодруулга



- ✓ Бодит үнэ цэнийн болон өртгийн загварын алийг хэрэглэж байгаа эсэх
- ✓ Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн тайлбар тодорхойлолт
- ✓ Бодит үнэ цэнийн тодорхойлолт
- ✓ Ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн дүн
- ✓ Хязгаарласан хөрөнгийн дүн
- ✓ Капиталжуулсан зардал
- ✓ Элэгдэл тооцсон арга, хорогдуулалтын хувь
- ✓ Тайлант хугацааны эхэн болон эцэс дэх дансны үнэ болон аливаа тохируулга



УСНББОУС 19

Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө

Б.Баатарцогт

Мандах их сургуулийн багш



Нөөцийн Тодорхойлолт

Нөөц гэдэг нь **тодорхой бус хугацаа** буюу дүн бүхий өр төлбөр юм.

Зүйл	Тайлбар	Тодорхой бус байдал	Ангилал
Дансны өглөг	Бараа үйлчилгээ: - Хүлээн авсан ба - Нэхэмжилж тохиролцсон	Тодорхой бус байдал үүсээгүй	Нөөц биш
Аккрузал	Бараа үйлчилгээ: - Хүлээн авсан гэхдээ - Төлөөгүй, нэхэмжлээгүй эсвэл тохиролцоогүй	Мэдэгдэхүйц тодорхой бус байдал үүсээгүй	Нөөц биш
Баталгаат хугацааны үүрэг	Зарагдсан бараа нь гэмтэлтэй байвал засах үүрэг	Мэдэгдэхүйц тодорхой бус байдал	Нөөц (Бусад нөхцлүүдийг хангасан тохиолдолд)



СТОУС Тодорхойлолт

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн бөгөөд түүний хүлээгдэж буй барагдуулалтаар эдийн засгийн үр өгөөж бүхий нөөцийг тухайн аж ахуйн нэгжээс зарцуулахад хүргэх уг аж ахуйн нэгжийн одоогийн үүрэг юм

Үүрэг хүлээлгэх үйл явдал - Тодорхойлолт

Тухайн үүргийг барагдуулахаас өөр бодит сонголтгүй болоход аж ахуйн нэгжийг хүргэдэг, хуулиар хүлээсэн үүрэг эсвэл гэрээний бус үүрэг үүсгэдэг үйл явдал юм



Үндсэн тодорхойлолтууд (Үргэлжлэл)

Хуулиар хүлээсэн үүрэг– Тодорхойлолт

Гэрээ (түүний илэрхий буюу далд утгатай нөхцлөөр), хууль тогтоомж эсвэл хуулийн бусад үйлчлэл зүйлсээс үүсдэг үүрэг юм

Гэрээний бус үүрэг

Өнгөрсөн практикын тогтсон хэв маяг, хэвлэн нийтэлсэн бодлого буюу хангалттай тодорхой заасан одоогийн мэдэгдлээр тухайн аж ахуйн нэгж нь зарим хариуцлагыг хүлээнэ гэдгээ бусад талуудад илэрхийлсэн байдлаас үүсэх үүрэг юм

Үүний үр дүнд, уг аж ахуйн нэгж нь тэдгээр хариуцлагыг биелүүлнэ гэсэн бодит хүлээлтийг нөгөө талдаа бий болгосон.



Хүлээн зөвшөөрөлтийн шалгуур -Нөөц

Дараах тохиолдолд нөөцийг хүлээн зөвшөөрнө :

- a) Байгууллага нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд одоогийн (хуулиар хүлээсэн эсвэл гэрээний бус) үүрэгтэй байх
- b) Үүргийг барагдуулахад шаардлагатай эдийн засгийн үр өгөөж бүхий нөөцийг зарцуулах магадлалтай байх
- c) Үүргийн дүнгийн талаар найдвартай тооцоолол хийж чадах

Тэмдэглэл:

- “Магадлалтай”: УСНББОУС-д 50%-аас дээшээ ба АНУ НХЗНББЗ-ын дагуу 50%- аас дээшээ гэдэг нь “Болохгүйгээс болох нь их”; АНУ НХЗНББЗ-д магадлалтай гэдгийг 70%-аас дээшээ гэж үздэг
- УСНББОУС ийн “Өндөр магадлалтай” нь АНУ НХЗНББЗ-ийн “магадлалтай” тай тэнцэнэ



Тодорхой бус байдал

Нэг л үүргийг хэмжиж буй тохиолдолд:

- Нэгжийн хамгийн өндөр магадлалтай үр дүн нь өр төлбөрийн хамгийн сайн нотолгоо байж болно.

Нөөц олон тооны зүйлсийг агуулж буй тохиолдолд:

- Хүлээгдэж буй бүх үр дүнгийн магадлалыг харгалзан үзсэн хүлээгдэх буй дүнгүүдийг ашиглах.

Нөөц ба Хасагдуулга

Нөөц:

- Өр төлбөрийн хэсэг.
- Тодорхой бус дүн бүхий одоогийн үүрэг

Хасагдуулга:

- Хөрөнгийн дансны үнийг бууруулдаг.
- Жишээ нь: Бараа материалыг цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл бууруулах; үндсэн хөрөнгийг нөхөгдөх дүн хүртэл бууруулах, найдваргүй авлагын дүнг бууруулах



Ирээдүйн үйл ажиллагааны алдагдал

Нөөц үүсгэх ёсгүй

- Алдагдал нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсэхгүй
- Зайлсхийж болно



Болзошгүй өр төлбөр - Хуульчийн Тодорхойлолт

Хуульчийн хувьд болзошгүй өр төлбөр бол ирээдүйн хуулийн шийдвэрээс хамаарах өр төлбөр. Түүний хувьд шийдвэрийн магадлал нь ямар ч хамаагүй.



Болзошгүй өр төлбөр - СТОУС

Болзошгүй өр төлбөр бол:

1. Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсдэг боломжит үүрэг ба

2. Түүний **оршин байдал** нь бүхэлдээ уг аж ахуйн нэгжийн хянах боломжгүй ирээдүйн нэг буюу хэд хэдэн тодорхой бус үйл явдлын **тохиолдолд** эсвэл **үл тохиолдолтоор** зөвхөн батлагдна

1. Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсдэг **одоогийн үүрэг ГЭХДЭЭ**

2. Уг үүргийг барагдуулахад **эсвэл** шаардлагатай эдийн засгийн үр өгөөж бүхий нөөцийг **зарцуулах** магадлалгүй тул **хүлээн зөвшөөрөөгүй**

1. Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсдэг **одоогийн үүрэг ГЭХДЭЭ**

2. Үүргийн дүнг хангалттай **найдвартайгаар** хэмжих боломжгүй

Тодорхойлолт

1. Дүнгийн талаар мэдэхгүй ч төлөх ёстой байж магадгүй эсвэл
2. Энэ бол магадлал

Гэхдээ өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн байх хэрэгтэй

Зөвхөн
тодруулна



Болзошгүй хөрөнгүүд

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсдэг **боломжит хөрөнгө**

- Бөгөөд түүний оршин байдал нь бүхэлдээ уг аж ахуйн нэгжийн хянах боломжгүй ирээдүйн нэг буюу хэд хэдэн тодорхой бус үйл явдлын **тохиолдолд** эсвэл **үл тохиолдолтоор** зөвхөн батлагдах

Орлого орж ирэх магадлал?

Магадлалтай гэхдээ үнэхээр
тодорхой биш?

Магадлалгүй?

Юу ч хийхгүй

**Зөвхөн
тодруулна**

Үнэхээр тодорхой?

Хамаарах
УСНББОУС -ын
дагуу бүртгэнэ

Болзошгүй хөрөнгө

Бодит хөрөнгө



Алдагдалтай гэрээ

Тодорхойлолт:

Алдагдалтай гэрээ гэдэг нь:

1. Үүргийг биелүүлэхэд гарах, **зайлсхийх боломжгүй** зардал нь
2. Хүлээгдэж буй эдийн засгийн үр өгөөжөөс **хэтрэх гэрээ юм**

**Үүрэг хүлээлгэх
үйл явдал**

Олгох дүн

Гэрээг зурах

Гэрээг алдагдалтай болгох үйл явдлууд

Нөөцөөр хэмжигднэ, гарах зардлын хамгийн бага нь

- Жишээ нь эдгээрээс хамгийн бага нь:

- **Гэрээг биелүүлэх зардал ба**

- **Цуцлах зардал**

Гэхдээ үнэ цэнийн бууралтын гарзыг холбогдох хөрөнгүүдийн хувьд хүлээн зөвшөөрсний дараа

- Гэрээний зардал болон үр өгөөж нь ерөнхий үйл ажиллагааны алдагдлаас ялгагдах хэрэгтэй.



Дасгал ажил 1 /Бүтцийн өөрчлөлт/

20х8 онд “А” Засгийн газар өөрийн улсад байрлах цэргийн төв байрыг дараа жилд хаах шийдвэр гаргасан. Энэ шийдвэр 5 цэргийн албан хаагчдад нөлөөлнө. Тэдгээр хүмүүст уг шийдвэрийн талаар захидлыг хүргүүлж мэдэгдсэн. Эдгээр албан хаагчдад ажлаас халагдсаны тэтгэмжинд нийт 4,000,000₮ зарцуулна гэж тооцсон ч 4 албан хаагчдыг өөр байгууллагад шилжүүлнэ гэж таамаглаж байгаа бол **20х8 онд нөөц үүсгэн бүртгэх үү.**

Хариулт:.....

Дт Бүтцийн өөрчлөлтийн зардал 800,000₮ /үр дүнгийн тайлан/

Кт Бүтцийн өөрчлөлтийн нөөц 800,000₮ /санхүү байдлын тайлан/



Бодолтын тайлбар 1

Үйл ажиллагаагаа зогсоосон нь УСНББОС-т зааснаар

УСНББОУС19.81-д бүтцийн өөрчлөлтийн тодорхойлолтод багтах үйл явдлын жишээг дор харуулав:

- Үйл ажиллагаа эсвэл үйлчилгээг худалдах буюу **зогсоох**;
- Засгийн газрын агентлагийн тодорхой байрлал эсвэл бүс дэх үйл ажиллагааг зогсоох, **салбараа хаах эсвэл үйл ажиллагааг нэг бүсээс нөгөө бүсрүү шилжүүлэн байршуулах**;
- Удирдлагын бүтэц дэх өөрчлөлт, жишээлбэл, удирдлагын нэг шатлалыг үгүй болгох
- Байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл болон шинж чанарт материаллаг нөлөө үзүүлэхүйц бүтцийн өөрчлөлтүүд.



Бодолтын тайлбар 2

5 албан хаагчийн 4-г өөр байгууллагадаа шилжүүлэн ажиллуулна гэж үзэж байгаа учраас уг 4 албан хаагчдад төлөх өр төлбөр буюу нөөц үүсгэн бүртгэх шаардлагагүй юм. Учир нь УСНББОУС19.94 Бүтцийн өөрчлөлтийн нөөц нь дараах зардлыг агуулахгүй:

- Үндсэн ажилчдыг давтан сургах буюу **шилжүүлэх**;
- Маркетинг; эсвэл
- Шинэ систем болон хуваарилалтын сүлжээнд хөрөнгө оруулалт хийх.



Дасгал ажил 2 /Алдагдалтай гэрээ/

20x8.01.01 нд А төсвийн байгууллага үймээн самуунтай бүс нутагт эм ханган нийлүүлэх гэрээг байгуулсан. Гэрээнд 3 жилийн хугацаанд сар бүр 20,000,000₮ өртөгтэй эмийг өртгөөр нь нийлүүлнэ. 20x9 оны жилийн эцсээр үймээн самуун арилж, мөн эмийг нийлүүлэх үйл ажиллагаа зогссон. А байгууллага гэрээг цуцалбал 100,000,000₮ торгууль төлөх, эсвэл тухайн үймээн самуунтай байсан бүс нутагт тухайн бараагаа гэрээний үнийн 75%-р хямдруулан борлуулах боломжтой бол 20x9.12.31-р нөөц үүсгэн бүртгэх үү?



**Хариулт /нөөцийг хүлээн зөвшөөрөх шалгууруудыг хангах учраас нөөц
үүсгэн бүртгэнэ.**

Дт Гэрээний алдагдал 60,000,000₮

Кт Нөөц/ өр төлбөр/ 60,000,000₮



Бодолтын тайлбар

Нөөц үүсгэн бүртгэх дүн нь гэрээг биелүүлэх зардал ба гэрээг үл биелүүлснээс үүсэх нөхөн төлбөр, торгуулийн **аль бага** байх учраас үүнийг тооцоолбол:

- Гэрээг үл биелүүлснээс үүсэх нөхөн төлбөр, торгууль = 100,000,000₮
- Гэрээг биелүүлэх зардал =
- $(20,000,000₮ - 20,000,000₮ * 75\%) * 12 \text{ сар} / \text{гэрээний үлдсэн хугацаа} = 60,000,000₮$



УСНББОУС 21

Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Х.Нямбаяр

Мандах их сургуулийн багш



Тодорхойлолт	Хүлээн зөвшөөрөх шалгуур
1. Байгууллагын хяналтад байгаа нөөц 2. Өнгөрсөн үйл явдлын үр дүн	1. Ирээдүйд эдийн засгийн өгөөж эсвэл үйлчилгээний чадавх авчрах магадлалтай байх 2. Найдвартай хэмжих боломжтой байх



Дансны үнэ ???

Өртгөөс түүний аливаа хуримтлагдсан элэгдэл ба аливаа хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн

Хөрөнгийн дахин үнэлсэн дүнгээс дараа үеийн аливаа хуримтлагдсан элэгдэл ба дараа үеийн хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн



МӨНГӨ БИЙ БОЛГОДОГГҮЙ ХӨРӨНГӨ

Байгууллагын хяналтад байгаа ирээдүйд **үйлчилгээний чадавхи** бий болгох бөгөөд арилжааны зорилгогүй байна.

Үнэ цэнийн бууралт

- Хөрөнгийн тодорхойлолтыг хангахын тулд үнэлгээний залруулга хийх шаардлагатай болгох үйл явдлаас үүснэ.
- Өөрөөр хэлбэл үйлчилгээний чадавх нь хөрөнгийн дансны үнийг нөхөх боломжгүй үед үүснэ.



Үлдэгдэл өртөг- Нөхөгдөх дүн= Үнэ цэнийн бууралт



АСУУДАЛ

**Үнэ цэнэ буурсан байж
болох шинж тэмдэг
илэрсэн эсэхийг шалгах**


• **ҮЕ ШАТ 1**



**Үнэ цэнэ буурсан шинж
тэмдэг илэрсэн бол
нөхөгдөх дүнг тооцоолох**

• **ҮЕ ШАТ 2**

1. Элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн арга
2. Нөхөн сэргээлтийн өртгийн арга
3. Үйлчилгээний нэгжийн арга



**Хөрөнгийн дансны
үнийг холбогдох дүн
хүртэл бууруулах**

• **ҮЕ ШАТ 3**

**Жил бүрийн үнэ цэнийн
бууралтын тест**

- Худалдан авсан гүүдвил
- Тодорхой бус ашиглалтын хугацаатай бусад биет бус хөрөнгө
- Ашиглалтанд бэлэн болоогүй биет бус хөрөнгө



Үе шат 1: Үнэ цэнийн бууралтыг илтгэх үзүүлэлтүүд

Үнэ цэнийн бууралтыг илтгэх хүчин зүйлсийн хоёр эх сурвалж байна:

Дотоод хүчин зүйлс

- Хөрөнгийн хуучралт буюу биет эвдрэл
- Хөрөнгийн ашиглалтын байдалд мэдэгдэхүйц сөрөг нөлөөтэй өөрчлөлтүүд гарсан
- Хөрөнгийг барьж байгуулах ажил дуусахаас өмнө барилгын ажлыг зогсоох
- Хөрөнгийн үйлчилгээний гүйцэтгэл хүлээгдэж байснаас мэдэгдэхүйц муу байх

Гадаад хүчин зүйлс

- Үйлчилгээний эрэлт хэрэгцээ буурсан
- Технологийн, хуулийн, засгийн газрын бодлогын өөрчлөлт



Мөнгө бий болгодоггүй хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Ашиглалтын үнэ цэнийг тодорхойлох мөнгөн гүйлгээ байхгүй тул УСНББОУС-д дараах 3 аргыг заасан

- 1. Элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн арга**
- 2. Нөхөн сэргээлтийн өртгийн арга**
- 3. Үйлчилгээний нэгжийн арга**



1. Элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн арга

- Элэгдсэн орлуулалтын өртгийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлно.
- Хөрөнгийн орлуулалтын өртөг нь хөрөнгийн нийт үйлчилгээний чадавхийг нөхөх өртөг юм. Хөрөнгийн ашиглагдсан нөхцөл байдлыг тусгах байдлаар өртгийг элэгдүүлнэ.
- Одоогийн хөрөнгийг дахин үйлдвэрлэх (олшруулах) эсвэл түүний үйлчилгээний нийт чадавхыг нөхөх замаар хөрөнгийг орлуулж болно.



Жишээ нь:

2015.01.01-нд Эрүүл мэндийн газар 100,000,000₮ өртөгтэй шинэ сервер худалдан авсан. Ашиглалтын хугацаа 8 жил гэж тооцсон. Ихэнх газрууд компьютер дээрх аппликейшнүүдээ ашиглах болсноор серверийн хэрэглээ 2017 оноос 20 хувь хүртэл буурсан.

2018.12.31-ний байдлаар дэвшилтэт компьютерийн зах зээл дээрх өнөөгийн үнэ 5,000,000₮ бөгөөд хуучин серверийн хүчин чадлыг орлох боломжтой. Шинэ дэвшилтэд компьютерийн ашиглалтын хугацаа мөн 8 жил бол:

2018.12.31-рх үнэ цэнийн бууралтын гарз хэд вэ? /Элэгдэл тооцсон орлуулалтын өртгийн арга ашиглана/

**Бодолт:**

Худалдан авалтын өртөг
Хуримтлагдсан элэгдэл
Дансны үнэ

100,000,000
(50,000,000)
50,000,000

 $100,000,000/8*4$

Орлуулалтын (нөхөгдөх) өртөг
Хуримтлагдсан элэгдэл
Элэгдсэн орлуулалтын (нөхөгдөх) өртөг

5,000,000
(2,500,000)
2,500,000

 $5,000,000/8*4$
Харьцуулах

2015.01.01-нд Эрүүл мэндийн газар 100,000,000₮ өртөгтэй шинэ сервер худалдан авсан. Ашиглалтын хугацаа 8 жил гэж тооцсон. Ихэнх газрууд компьютер дээрх аппликейшнүүдээ ашиглах болсноор серверийн хэрэглээ 2017 оноос 20 хувь хүртэл буурсан. 2018.12.31-ний байдлаар дэвшилтэт компьютерийн зах зээл дээрх өнөөгийн үнэ 5,000,000₮ бөгөөд хуучин серверийн хүчин чадлыг орлох боломжтой. Шинэ дэвшилтэд компьютерийн ашиглалтын хугацаа мөн 8 жил бол:

2018.12.31-рх үнэ цэнийн бууралтын гарз хэд вэ?
/УСНББОУС21-Элэгдсэн нөхөгдөх өртгийн арга ашиглана/

Үнийн бууралтын гарз= 50,000,000 - 2,500,000=47,500,000 төгрөг



2. Нөхөн сэргээлтийн өртгийн арга

Нөхөн сэргээх өртөг гэдэг нь хөрөнгийн үйлчилгээний чадавхийг үнэ цэнийн бууралтын өмнөх түвшинд аваачиж сэргээх өртөг юм.

Энэ аргаар:

- Үнэ цэнийн бууралтын өмнөх өнөөгийн **өртгөөс хөрөнгийг нөхөн сэргээх тооцоолсон өртгийг хасч** өнөөгийн үнэ цэнийг тодорхойлно.
- Үнэ цэнийн бууралтын өмнөх өнөөгийн өртгийг хөрөнгийн элэгдсэн **дахин бүтээн бий болголтын өртөг** эсвэл нөхөгдөх өртгийн аль багаар ихэвчлэн тодорхойлдог.



Жишээ нь:

2013.01.01-нд “А” байгууллага ажилчдыг тээвэрлэх автобус 55,000,000 төгрөгөөр худалдан авсан. Ашиглалтын хугацаа 10 жил. /ШША/ 2 жил ашигласны эцэст зам тээврийн осол гарч 8,000,000 төгрөгний засвар хийх шаардлагатай болсон. Шинэ автобусны өртөг энэ үед 60,000,000 төгрөг байсан бол:

Нөхөн сэргээх өртгийн аргаар хөрөнгийн үнийн бууралтыг үнэлнэ үү.

**Бодолт:**

Худалдан авалтын өртөг
Хуримтлагдсан элэгдэл
Дансны үнэ

Орлуулалтын өртөг
Хуримтлагдсан элэгдэл
Элэгдэл тооцсон орлуулалтыг өртөг
Хасах: Нөхөн сэргээх өртөг
Нөхөгдөх үйлчилгээний дүн

55,000,000
(11,000,000)
44,000,000

60,000,000
(12,000,000)
48,000,000
(8,000,000)
40,000,000

 $55,000,000/10*2$ $60,000,000/10*2$ **Харьцуулах**

Үнийн бууралтын гарз $44,000,000 - 40,000,000 = 4,000,000$ төгрөг

ᠲᠠᠬᠢᠨ ᠰᠡᠷᠭᠡᠭᠡᠬᠡ ᠦ᠋ᠷᠲᠦᠭᠢᠨ ᠠᠷᠭᠠᠭ ᠬᠥᠷᠦᠩᠭᠢᠨ ᠤᠨᠢᠶᠢᠨ ᠪᠤᠭᠤᠷᠠᠯᠲᠦᠭ

2013.01.01-нд “А” байгууллага ажилчдыг тээвэрлэх автобус 55,000,000 төгрөгөөр худалдан авсан. Ашиглалтын хугацаа 10 жил. /ЛША/ 2 жил ашигласны эцэст зам тээврийн осол гарч 8,000,000 төгрөгний засвар хийх шаардлагатай болсон. Шинэ автобусны өртөг энэ үед 60,000,000 төгрөг байсан бол:

Дахин сэргээх өртгийн аргаар хөрөнгийн үнийн бууралтыг үнэлнэ үү.



3. Үйлчилгээний нэгжийн арга

- Үнэ цэнэ буурсан нөхцөл байдалд хөрөнгөөс хүлээгдэж буй **үйлчилгээний нэгжийн буурсан тоотой үнэ цэнийн бууралтын өмнөх өнөөгийн өртгийг нийцүүлэн бууруулах** замаар өнөөгийн үнэ цэнийг тодорхойлдог.
- Дахин сэргээх өртгийн аргын адилаар үнэ цэнийн бууралтын өмнөх хөрөнгийн үлдэж буй **үйлчилгээний чадавхыг нөхөх** өнөөгийн өртгийг үнэ цэнийн бууралтын өмнөх хөрөнгийн элэгдсэн дахин сэргээлтийн эсвэл нөхөгдөх өртгийн аль багаар ихэвчлэн тодорхойлдог



Жишээ нь:

“А” байгууллага 10 давхар барилгыг нийт 148,000,000 төгрөгийн өртөгтэйгөөр барьсан. Барилгын ашиглалтын хугацаа 40 жил. Барилгыг 4 жил ашигласны эцэст аюулгүй байдлын улмаас уг барилгын дээд 2 давхарыг тодорхой бус хугацаагаар ашиглахыг хориглосон.

Акт тавигдсны дараах барилгын үнэ цэнэ 100,000,000 төгрөг болсон.

Үүнтэй ижил барилга барих одоогийн өртөг 160,000,000 төгрөг.

Үйлчилгээний нэгжийн хандлагаар үнийн бууралтыг тооцоолно уу.

**Бодолт:**

Орлуулалтын өртөг	160,000,000	
Хуримтлагдсан элэгдэл	<u>(16,000,000)</u>	$160,000,000/40*4$
Үлдэх үйлчилгээний нэгжийн хувьд залруулга хийхээс өмнөх элэгдэл тооцсон орлуулалтын өртөг	144,000,000	
Акт тавьсны дараах ашиглалтын үнэ цэнэ	115,200,000	} Аль их нь нөхөгдөх дүн
144,000,000*8/10=115,200,000		
Акт тавьсны дараах борлуулалтын үнэ цэнэ		
100,000,000		
Нөхөгдөх дүн	115,200,000	



Бодолт:

Барилгын өртөг

148,000,000 $148,000,000/40*4$

Хуримтлагдсан элэгдэл

(14,800,000)

Дансны үнэ

133,200,000

Нөхөгдөх дүн

115,200,000

Харьцуулах

Хөрөнгийн үнэ цэнийн бууралт $132,200,000 - 115,200,000 = 17,000,000$ төгрөг



3-р шат - Үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх

Түүхэн өртгөөр бүртгэлтэй
байгаа хөрөнгүүд

Дахин үнэлэгдсэн хөрөнгүүд

Дебет
бичилт

Орлогын
тайланд зардал

УСНББОУС 17

- Эхлээд СБТ-г ашиглаад
- Дараа нь Орлогын тайлан



Үнэ цэнийн бууралтын гарзыг буцаах

- Хамгийн сүүлийн үнэ цэнийн бууралтын газрыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн үйлчилгээний нөхөгдөх дүнг тодорхойлоход ашигласан тооцоололд өөрчлөлт гарсан тохиолдолд л буцаалт хийнэ.
- Хэрэв дээрх зүйл тохиолдсон бол дансны үнийг үйлчилгээний нөхөгдөх дүн хүртэл өсгөнө. Энэ өсөлт нь үнэ цэнийн бууралтын буцаалт юм.



УСНББОУС 23

Арилжааны бус ажил гүйлгээний орлого


Х.Нямбаяр

Мандах их сургуулийн багш



Орлого: Өмч эзэмшигчдээс оруулсан хувь оролцооноос бусдаар цэвэр хөрөнгө /өмчийг өсгөх нөлөөтэй хөрөнгийн орлогын гүйлгээ буюу сайжралт, эсвэл өр төлбөрийн бууралт хэлбэрээр тухайн тайлант үед үүссэн эдийн засгийн өгөөжийн өсөлт юм.

Арилжааны ажил
гүйлгээний
орлого



Арилжааны бус
ажил гүйлгээний
орлого

Хүлээн зөвшөөрөлт: Ирээдүйн эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхийг байгууллага хүртэх нилээд магадлалтай бөгөөд хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой бол орлогыг хүлээн зөвшөөрнө.



Арилжааны ба арилжааны бус ажил гүйлгээ

Арилжааны ажил гүйлгээ

- Бараа, үйлчилгээний худалдан авалт буюу борлуулалт;
- Зээлийн хүү;
- Эрхийн шимтгэл буюу лицензийн төлбөр;
- Хөрөнгө оруулалтын ногдол ашиг.

Арилжааны бус ажил гүйлгээ

- Татвар
- засгийн газрын буцалтгүй тусламж;
- Өрөөс чөлөөлөлт
- Бэлэг, хандив
- Өвлүүлсэн хөрөнгө
- Торгууль.

Тодорхойлолт: УСНББОУС 9: Арилжааны ажил гүйлгээ

Тухайн байгууллага хөрөнгө буюу үйлчилгээг хүлээн авах, эсвэл өр төлбөрийг барагдуулах ба үүний хариуд ойролцоогоор тэнцүү үнэ цэнэ бүхий зүйлсийг нөгөө талдаа өгдөг ажил гүйлгээ



Мөнгөний үнэ цэнэ

Хадгаламжийн хүү 12%

Өнөөдөр 1,000,000₮

1 жилийн дараах 1,120,000₮

1 жилийн дараах 1,000,000₮

$$\text{Өнөөдөрийн } 1,000,000 \times \frac{1}{(1+0.12)^1} = 892,857.14₮$$



Төрөл бүрийн татвар,
хураамж

- Буцалтгүй тусламж
- Өрийн чөлөөлөлт,
- Торгууль,
- Өвлүүлсэн хөрөнгө,
- Бэлэг, хандив,
- Үнэгүй олгосон бараа, үйлчилгээ...



Шилжүүлсэн хөрөнгийн хувьд хийсэн тохиролцоо


(Шилжүүлсэн хөрөнгийг хүлээсэн авснаар зайлшгүй биелүүлэх гэрээ)

Нөхцлүүд

Хөрөнгийг хэрхэн ашиглах ба шилжүүлэгчид буцааж өгөх ёстой эсэх талаар тусгайлан заах.

Хязгаарлалтууд

Хөрөнгийг ашиглалтад хязгаарлалт тавих эсвэл удирдан чиглүүлэх





Арилжааны бус

Арилжааны

Шинж чанар

Гүйцэтгэлийн үүрэг
эсвэл тохиролцсон
нөхцөл байхгүй

Нөөцийг тусгайлсан
заасан хэлбэрээр
ашиглаж, зарцуулах
талаарх гүйцэтгэлийн
үүрэг эсвэл тохиролцсон
нөхцөлтэй зайлшгүй
биелүүлэх хэлцэл; эсвэл
тодорхой хугацаанд
нөөцийг ашиглахыг
шаардах бусад хэлцлүүд

Арилжааны нөхцлөөр
бараа, үйлчилгээг
хэрэглэгчдэд
шилжүүлэх
гүйцэтгэлийн
үүрэгтэй зайлшгүй
биелүүлэх хэлцэл

Жишээ

Татвар, шилжүүлэг

Вакцинжуулалтыг
санхүүжүүлэх

Арилжааны
нөхцлөөрх бараа,
үйлчилгээний
борлуулалт



Хандлага 1 – Өргөтгөсөн үүргийн үйл явдлын арга хандлага

УСНББОУС 23 арга хандлага

Орлогыг хүлээн зөвшөөрөх үндсэн зарчим


1. Байгууллага солилцооны бус гүйлгээнээс хөрөнгө хүлээн зөвшөөрч чадах эсэхийг тодорхойлох.
2. Ажил гүйлгээ нь нөхцөл эсвэл хязгаарлалт бий болгосон эсэхийг тодорхойлох.
3. Холбогдох үүрэг биелэгдсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрөх
4. Аж ахуйн нэгжийн хүлээн зөвшөөрсөн цэвэр хөрөнгийн өсөлтийн дүнгээр орлогыг хэмжинэ.



Арилжааны бус орлого : Хоёрдугаар арга хандлага

Хандлага 2 – Улсын секторын гүйцэтгэлийн үүргийн арга хандлага

- Нөөцөөр хангагчийн үүднээс хандаж улсын секторын гүйцэтгэлийн үүргийн арга хандлагыг дахин бүтэцчилсэн





УСНББОУС 24

Төсвийн нягтлан бодох бүртгэл

Багш: Д.Бүнчинсүрэн

МУИС-ийн БС-ийн багш



Зорилго ба шаардлага

Батлагдсан төсвийг мөрдөн ажиллаж, олон нийтийн өмнө тайлагнаж байх зорилготой

Стандарт дараах зүйлсийг шаардсан:

- Байгууллага өөрсдийн батлагдсан төсвийг олон нийтэд нээлттэй байлгах шаардлагатай эсвэл тийм сонголт хийсэн бол төсөв ба гүйцэтгэлийг харьцуулах
- Төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн хооронд материаллаг зөрүүгийн тайлбарыг тодруулах

Тэмдэглэл: Стандарт батлагдсан төсвийг олон нийтэд ил тод болгохыг эсвэл үүний талаарх мэдээллийг тодруулахыг эсвэл олон нийтэд ил тод болоогүй батлагдсан төсвүүдийг харьцуулахыг шаардаагүй.



Гол тодорхойлолтууд

Анхны төсөв = тухайн төсвийн хугацаанд анхлан батлагдсан төсөв

Батлагдсан төсөв = хууль, төсвийн хуваарилалтын мэдэгдэл, засгийн газрын тогтоол болон тухайн төсвийн хугацааны урьдчилан төсөөлсөн орлого буюу мөнгөн орлоготой холбоотой бусад шийдвэрээр үүсэх зарлагын эрх

Тодотгосон төсөв = тухайн төсвийн хугацаанд хамаарах бүх нөөц, өмнөх үеэс шилжиж ирсэн дүн, шилжүүлэг, хуваарилалт, нэмэлт төсвийн хуваарилалт болон бусад зөвшөөрөгдсөн хууль тогтоомжийн буюу адилтгах бүрэн эрхийн дагуу хийгдсэн өөрчлөлтийн хувьд тохируулга хийсэн анхны төсөв

Төсвийн суурь = хууль тогтоогч байгууллагаас баталсан тухайн төсөвт мөрддөг аккрузл, мөнгөн ба бусад суурь

Жилийн төсөв = төсвийн тайлант хугацаанаас цааших хугацаанд хамаарах хэвлэгдсэн ирээдүйн тооцоолол эсвэл төсөөллийг оруулахгүйгээр нэг жилийн хувьд батлагдсан төсөв.



Төсөв ба гүйцэтгэлийн зэрэгцүүлсэн толилуулга

Тусдаа нэмэлт санхүүгийн тайлан байдлаар эсвэл санхүүгийн тайланд нэмэлт төсвийн багана хэлбэрээр толилуулна.

Хууль тогтоомжийн хяналтын түвшин бүрийн хувьд төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн хоорондох зэрэгцүүлэлтийг тусад нь толилуулна:

- a) Анхны болон тодотгосон төсвийн дүнгүүд;
- b) Зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэлийн дүнгүүд (төсвийн гүйцэтгэлийн дүнгүүд);
- c) Дээрх дүнгийн хоорондох материаллаг зөрүүгийн талаархи тайлбарыг уг санхүүгийн тайлангийн хамтаар гаргаж, олон нийтэд танилцуулдаг бусад баримт бичигт тусган оруулдаг бөгөөд тэдгээр баримт бичигт харилцан лавлагаа үүсгэж, санхүүгийн тайлангийн тодруулгад харуулдагаас бусад тохиолдолд тэмдэглэл тодруулга хэлбэрээр хийх тайлбар.

Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох бүх зэрэгцүүлэлтийг тухайн төсөвтэй зэрэгцүүлэгдэх сууриар толилуулна. (төсвийн суурийг ашиглана)



Санхүүгийн тайлангийн тэмдэглэлд тайлбарлан оруулах зүйлс:


- Батлагдсан төсөвт хэрэглэсэн төсвийн суурь ба ангиллын суурь,
Төсвийн суурь нягтлан бодох бүртгэлийн сууриас ялгаатай байж болно. Нягтлан бодох бүртгэлийн суурь нь зардлын шинж чанар, чиг үүргийг ашигладаг бол харин төсвийн суурь нь тодорхой хөтөлбөр, зорилгуудад суурилсан ангиллыг хэрэглэж болох тул ангиллын суурь зөрүүтэй байж болно.
- Батлагдсан төсвийн тайлант хугацаа,
- Батлагдсан төсөвт хамаарсан байгууллагууд.




Төсвийн харьцуулалтын толилуулга

Санхүүгийн тайлан ба төсвийг зэрэгцүүлэх сууриар бэлтгэдэг бол төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн харьцуулалтыг санхүүгийн тайланд төсвийн багана нэмэх замаар толилуулж болно.


Санхүүгийн тайлан ба төсвийг зэрэгцүүлэх сууриар бэлтгэдэггүй бол (аккруэл ба мөнгөн сууриар гэх мэт), “Төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн зэрэгцүүлэлтийн тайлан” гэсэн тусдаа тайланг толилуулна.



Төсөв



Төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн
зэрэгцүүлэлтийн тайлан



Санхүүгийн тайлан



Жишээ – Төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн зэрэгцүүлэлтийн тайлан

Орлого, зардлын үзүүлэлт	Анхны төсөв	Тодотгосон төсөв	Зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ОРЛОГО					
Татварын бус орлого	786,000	786,000	959,400	173,400	22.06%
Санхүүжилтийн орлого	710,200	710,000	709,000	(1,000)	-0.14%
Нийт орлого	1,496,200	1,496,000	1,668,400	172,400	11.52%
ЗАРДАЛ					
Цалин, хөлс, нэмэгдэл урамшуулал	578,000	585,000	583,800	(1,200)	-0.21%
Хэрэглээний ба хангамжийн зардал	183,000	190,000	186,000	(4,000)	-2.11%
Элэгдэл, хорогдлын зардал	218,000	218,000	221,000	3,000	1.38%
Бусад зардал	517,200	503,000	670,000	167,000	33.20%
Нийт зардал	1,496,200	1,496,000	1,660,800	164,800	11.02%
Тайлант жилийн ашиг, алдагдал	-	-	7,600	7,600	



Зэрэгцүүлэгдэх сууриар тусгасан гүйцэтгэлийн дүн ба санхүүгийн тайлан дахь гүйцэтгэлийн дүнгийн хоорондох тохируулга

- Санхүүгийн тайлан ба төсвийг зэрэгцүүлэгдэх сууриар бэлтгэдэггүй бол төсөвтэй зэрэгцүүлэгдэх сууриар толилуулсан гүйцэтгэлийн дүнг санхүүгийн тайланд толилуулсан дараах дүнтэй аливаа суурь, цаг хугацаа болон байгууллагын зөрүүтэй байдлыг тусад тодорхойлно:
 - Хэрэв төсөвт аккрузл суурийг хэрэглэдэг бол нийт орлого, нийт зардал, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт ба санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ
 - Хэрэв төсөвт аккрузл сууриас өөр суурийг хэрэглэдэг бол болон үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт ба санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ
- Уг тохируулгыг “Төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн харьцуулалтын тайлан”-д эсвэл санхүүгийн тайлангийн тодруулга хэсэгт тусгана.
- Өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээллийн тодруулгыг хийх шаардлагагүй.
- УСНББОУС 24-ийн Хавсралтад “Төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн зэрэгцүүлэлтийн тайлан”-ийн үлгэрчилсэн жишээг харуулсан.



Гүйцэтгэлийн дүнгийн тохируулга

Холбогдох тохируулгыг зэрэгцүүлэлтийн тайлангийн нүүрэнд эсвэл санхүүгийн тайлангийн тэмдэглэлд толилуулж болно. Үүнийг дараах үзүүлэлтээр харуулна:

	Үйл ажиллагааны МГ	Санхүүгийн МГ	Хөрөнгө оруулалтын МГ	Нийт
Төсөв ба гүйцэтгэлийн зэрэгцүүлсэн тайланд толилуулсан зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэлийн дүн	Х	Х	Х	Х
Суурийн зөрүү	Х	Х	Х	Х
Цаг хугацааны зөрүү	-	-	-	-
Байгууллагын зөрүү	Х	Х	Х	Х
Мөнгөн гүйлгээний тайлан дахь гүйцэтгэлийн дүн	Х	Х	Х	Х

Мөнгөн ба
аккруэл
суурь гэх мэт
Тухайлбал,
төсвийн хугацаа
ба санхүүгийн
тайлангийн
хугацаа

Санхүүгийн тайланд багтсан зарим байгууллагыг төсөвт оруулаагүй гэх мэт



Жишээ - Гүйцэтгэлийн дүнгийн тохируулга

	ҮАМГ	СМГ	ХОМГ	Нийт
Төсөв ба гүйцэтгэлийн зэрэгцүүлсэн тайланд толилуулсан зэрэгцүүлэгдэх сууриар илэрхийлсэн гүйцэтгэлийн дүн	(2,508,012)	-	-	(2,508,012)
Суурийн зөрүү	2,528,805	-	-	2,528,805
Цаг хугацааны зөрүү	-	-	-	-
Байгууллагын зөрүү	326,000	-	-	326,000
Толилуулгын зөрүү	54,691	(54,691)	-	-
Мөнгөн гүйлгээний тайлан дахь гүйцэтгэлийн дүн	401,484	(54,691)	-	346,793



УСНББОУС 26

Мөнгө бий болгогч хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Х.Нямбаяр

Мандах их сургуулийн багш



Тодорхойлолт	Хүлээн зөвшөөрөх шалгуур
1. Байгууллагын хяналтад байгаа нөөц 2. Өнгөрсөн үйл явдлын үр дүн	1. Ирээдүйд эдийн засгийн өгөөж эсвэл үйлчилгээний чадавх авчрах магадлалтай байх 2. Бодитой хэмжих боломжтой байх



Дансны үнэ ???

Өртгөөс түүний аливаа хуримтлагдсан элэгдэл ба аливаа хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн

Хөрөнгийн дахин үнэлсэн дүнгээс дараа үеийн аливаа хуримтлагдсан элэгдэл ба дараа үеийн хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн




Арилжааны өгөөж эсвэл зарлагыг нөхөх орлого бий болгох үндсэн зорилгоор эзэмшиж буй хөрөнгө

Ашгийн төлөө байгууллагатай ижил хэв маягаар байршуулсан үед хөрөнгө **арилжааны өгөөж** бий болгодог.

Үнэ цэнийн бууралт

- Хөрөнгийн тодорхойлолтыг хангахын тулд үнэлгээний залруулга хийх шаардлагатай болгох үйл явдлаас үүснэ.
- Өөрөөр хэлбэл хөрөнгийн үр өгөөж нь хөрөнгийн дансны үнийг нөхөх боломжгүй үед үүснэ.



Үлдэгдэл өртөг- Нөхөгдөх дүн= Үнэ цэнийн бууралт



**Үнэ цэнэ буурсан байж
болох шинж тэмдэг
илэрсэн эсэхийг шалгах**

• **ҮЕ ШАТ 1**

**Жил бүрийн үнэ цэнийн
бууралтын тест**

- Худалдан авсан гүүдвил
- Тодорхой бус ашиглалтын хугацаатай бусад биет бус хөрөнгө
- Ашиглалтанд бэлэн болоогүй биет бус хөрөнгө

**Үнэ цэнэ буурсан шинж
тэмдэг илэрсэн бол
хөрөнгийн нөхөгдөх дүнг
тодорхойлох**

• **ҮЕ ШАТ 2**

**Хөрөнгийн дансны
үнийг нөхөгдөх дүн
хүртэл бууруулах**

• **ҮЕ ШАТ 3**



Үе шат 1: Үнэ цэнийн бууралтыг илтгэх үзүүлэлтүүд

Үнэ цэнийн бууралтыг илтгэх хүчин зүйлсийн хоёр эх сурвалж байна:

Дотоод хүчин зүйлс

- Хөрөнгийн хуучралт буюу биет эвдрэл
- Хөрөнгийн ашиглалтын байдалд мэдэгдэхүйц сөрөг нөлөөтэй өөрчлөлтүүд гарсан
- Хөрөнгийг барьж байгуулах ажил дуусахаас өмнө барилгын ажлыг зогсоох
- Хөрөнгийн үйлчилгээний гүйцэтгэл хүлээгдэж байснаас мэдэгдэхүйц муу байх

Гадаад хүчин зүйлс

- Зээлийн үнэ цэнэ нь хүлээгдэж байснаас илүүтэйгээр мэдэгдэхүйц унасан
- Технологийн, зах зээлийн, эдийн засгийн болон хууль зүйн орчинд мэдэгдэхүйц сөрөг нөлөөтэй өөрчлөлтүүд гарсан
- Тайлант хугацаанд зах зээлийн хүүгийн түвшин өссөн



Нөхөгдөх дүн =

Эдгээрээс аль их нь

Данснаас хасах зардлыг хассан
бодит үнэ цэнэ

Хэвийн ажил гүйлгээгээр
хөрөнгийг борлуулснаар хүлээн
авах дүнгээс данснаас хасах
зардлыг хассан дүн

- Гол нотолгоо нь борлуулалтын гэрээ
- Гэрээний үнийг ашиглана
- Хасах нь: зарахад гарах зардал

Ашиглалтын үнэ цэнэ

Хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч
нэгжээс бий болохоор хүлээгдэж буй
ирээдүйн мөнгөн гүйлгээний
өнөөгийн үнэ цэнэ юм.

- Удирдлагын баталгаажуулсан төсөв
 - Татвараас өмнөх хувь хэмжээгээр
дискаунтлана
1. *КЖДӨ*
 2. *Өсөн нэмэгдэх зээлийн хүү*
 3. *Зах зээлийн бусад хүү.*



3-р шат - Үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөх

Түүхэн өртгөөр бүртгэлтэй
байгаа хөрөнгүүд

Дахин үнэлэгдсэн хөрөнгүүд

Дебет
бичилт

Орлогын
тайланд зардал

УСНББОУС 17

- Эхлээд СБТ-г ашиглаад
- Дараа нь Орлогын тайлан



Тодорхойлолт: Бусад хөрөнгө буюу хөрөнгүүдийн бүлгийн мөнгөн орлогоос бүрэн хамааралгүй байдлаар мөнгөн орлогыг бий болгодог хөрөнгүүдийн тодорхойлж болох хамгийн бага бүлэг юм.

Асуудал

Автобусны компани нь хүүхдүүдийг сургууль гэрийн хооронд хүргэж өгөх гэрээтэй.

Нийтдээ 10 чиглэлтэй.

Эдгээрээс 1 чиглэл нь алдагдалтай ажилладаг. Учир нь алслагдмал газраас хүүхдүүдийг авдаг болохоор хотоос авдаг чиглэлээс хамаагүй бага хүүхдүүд суудаг байна.

Шийдэл

Автобусны компани нь алдагдалтай ажилладаг чиглэлд үйл ажиллагаагаа явуулахаас татгалзах эрх байхгүй. Учир нь 10 чиглэл нь нэг бүлэг болж гэрээнд тусгагдсан.

Тиймээс 10 чиглэл нь нийтдээ нэг мөнгө бий болгогч нэгж болно.



Үнэ цэнийн бууралтын гарзыг дараах дарааллаар хуваарилна:

- а) Эхлээд хуваарилсан гүүдвилрүү**
- б) Дараа нь бусад хөрөнгө рүү хувь тэнцүүлсэн байдлаар**

Мөнгө бие болгогч нэгж доторх бие даасан хөрөнгийн үнэ цэнийн бууралт нь тухайн хөрөнгө дан ганцаараа зарагдах дүнгээс доошгүй байна.

2,500



0



5,000





Үнэ цэнийн бууралт: Тусдаа хөрөнгө

2018.01.01-нд “А” байгууллага 720,000 төгрөгөөр хөрөнгө худалдан авсан. Хөрөнгийг цаашид 6 жил ашиглахаар тооцож шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

2018.12.31-нд уг хөрөнгийг ашиглалт өөрчлөгдсөн учир ирээдүйн орох мөнгөн урсгал буурсан. Байгууллага хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болзошгүй гэж үзсэн.

Дискаунтын түвшин 10%. Энэхүү хөрөнгийг ашигласнаар 5 жилийн хугацаанд 95,000 төгрөг олно гэж тооцоолсон. Уг хөрөнгийг худалдах боломжгүй.

Үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойл.



Үнэ цэнийн бууралт: Тусдаа хөрөнгө

2018.01.01-нд “А” байгууллага 720,000 төгрөгөөр хөрөнгө худалдан авсан. Хөрөнгийг цаашид 6 жил ашиглахаар тооцож шулуун нугамын аргаар элэгдүүлнэ.

2018.12.31-нд уг хөрөнгийг ашиглалт өөрчлөгдсөн учир ирээдүйн орох мөнгөн урсгал буурсан. Байгууллага хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болзошгүй гэж үзсэн.

Дискаунтын түвшин 10%. Энэхүү хөрөнгийг ашигласнаар 5 жилийн хугацаанд 95,000 төгрөг олно гэж тооцоолсон. Уг хөрөнгийг худалдах боломжгүй.

2018.12.31-ээрх дансны үнийг тооцоолъё.

Хуримтлагдсан элэгдэл= $720,000/6=120,000$ төгрөг.

Дансны үнэ= $720,000-120,000=600,000$ төгрөг болно.



1. КЖДӨ

2. Өсөн нэмэгдэх

зээлийн хүү

3. Зах зээлийн

бусад хүү.

Үнэ цэнийн бууралт: Тусдаа хөрөнгө

2018.01.01-нд “А” байгууллага 720,000 төгрөгөөр хөрөнгө худалдан авсан. Хөрөнгийг цаашид 6 жил ашиглахаар тооцож шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

2018.12.31-нд уг хөрөнгийг ашиглалт өөрчлөгдсөн учир ирээдүйн орох мөнгөн урсгал буурсан. Байгууллага хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болзошгүй гэж үзсэн.

Дискаунтын түвшин 10%. Энэхүү хөрөнгийг ашигласнаар 5 жилийн хугацаанд 95,000 төгрөг олно гэж тооцоолсон. Уг хөрөнгийг худалдах боломжгүй.

Үнэ цэнэ буурсан эсэхийг тодорхойл.

- Ашиглалтын үнэ цэнэ $= 95,000 * \frac{1 - \frac{1}{(1+0,1)^5}}{0.1} = 360,125$
- Нөхөгдөх дүнгээс хэтэрсэн дансны үнийн хэмжээгээр үнийн бууралтын гарз үүснэ. (600,000-360,125=239,875)

**Үнэ цэнийн бууралт: Мөнгө бий болгогч нэгж**

2018 оны 12 сард байгууллагын хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болзошгүй шинж тэмдэг илэрсэн тул байгууллагын хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолсон. Ашиглалтын үнэ цэнэ 12,000 сая төгрөг байсан ба борлуулалтын зардлыг хассан БҮЦ-ийг дараах байдлаар тооцсон.

